




ГОВИЙН ОЮУ
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН 2015-2016

ТАНЫ ОРОЛЦОО-ТОГТВОРТОЙ
ХӨГЖЛИЙН ҮНДЭС



ГОВИЙН ОЮУ
ХӨГЖЛИЙГ
ДЭМЖИХ САН



АГУУЛГА

Хамтын ажиллагааны гэрээ, “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”	4-6
“Говийн оюу ХДС”-гийн Удирдах зөвлөлийн даргын мэндчилгээ	8
“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гийн засаглал	9-11
Сангийн бүтэц, зохион байгуулалт	9
Сангийн Удирдах зөвлөл	10
Харилцааны хороо	11
“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-д хүлээн авах төсөл, хөтөлбөрийн саналын чиглэл, шалгуур	12-15
Санхүүжилт олгох үндсэн чиглэл	12
Ашгийн бус, нийгэмд чиглэсэн саналыг санхүүжүүлэх шалгуур	13
Төсөл, хөтөлбөр хүлээн авч санхүүжилт олгох үе шат	14
Ирээдүй хойч үеийн төлөө сан	15
“Говийн оюу-Оюутны тэтгэлэг” хөтөлбөр	15
Батлагдсан төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт	16-19
Сангийн 2016 онд Өмнөговь аймагт оруулсан хөрөнгө оруулалт	17
Сангийн Удирдах зөвлөлөөс баталсан төсөл, хөтөлбөрүүд	19
2015 онд батлагдсан төслийн хэрэгжилт	20
2016 онд хэрэгжсэн Нийгмийн дэд бүтцийн чиглэлийн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт	21-25
Байгаль орчны менежментийн чиглэлийн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт	26-28
Нийгмийн суурь үйлчилгээний чиглэлийн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт	29-39
Мал аж ахуйн чиглэлийн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт	40-41
Үндэсний түүх соёл, аялал жуулчлалын чиглэлийн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт	42-45
Усны менежментийн чиглэлийн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт	46
Харилцагч байгууллагууд	47-48
Санхүүгийн тайлан	50-51



ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ

“Оюу толгой” компани нь 2015 оны 4 дүгээр сарын 22 нд Монгол Улсын Ашигт малтмалын тухай хууль болон бусад хууль тогтоомж, тус компанийн хөрөнгө оруулагч Рио Тинто компанийн олон улсад мөрддөг стандарт журмын дагуу Хамтын ажиллагааны гэрээг Оюу толгойн уурхай үйл ажиллагаагаа явуулж байгаа Өмнөговь аймаг болон тус аймгийн Ханбогд сумтай байгуулсан юм. Энэ нь Өмнөговь аймаг төдийгүй Монгол улсын хэмжээнд уул уурхайн компани нутгийн захиргааны байгууллагатай иж бүрэн Хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж буй анхны жишээ болсон билээ.

Олон улсын туршлагаас үзэхэд уул уурхайн салбар тогтвортой хөгжлийн зорилтуудыг хангахад чухал үүрэг гүйцэтгэх боломжтой гэж дэлхий нийтээр үзэж байна. Сүүлийн 10 орчим жил дэлхий дахинаа уул уурхайн салбарын нийгмийн хариуцлагын асуудал цоо шинэ түвшинд гарч, Рио Тинто, Англо Американ, Ньюмонт зэрэг томоохон компаниудын хувьд нийгмийн хариуцлага, орон нутгийн тогтвортой хөгжилд оруулах чухал бодлого, стандартуудыг гаргаж, тэр хэмжээгээр зах зээл дэх нэр хүнд нь сайжрах болов. Үүнд орон нутгийн захиргаа, иргэдийн төлөөлөлтэй хамтын ажиллагааны гэрээ байгуулан итгэлцэлд суурилсан харилцан ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлэх явдал чухал байр суурь эзэлдэг. Хамтын ажиллагааны гэрээний зорилго нь зөв ойлголцол, итгэлцэл, хариуцлага, түншлэл, орон нутгийн хөгжлийн үр өгөөж, компанийн үйл ажиллагааны тогтвортой орчин зэрэг давуу талуудыг бий болгодгийг олон улсын туршлага харуулдаг.

Хамтын ажиллагааны гэрээ нь талуудын урт хугацааны харилцаа, хамтын ажиллагааны зарчим, зорилтуудыг тодорхойлж, хамгийн чухал нь түүнийг хэрэгжүүлэх сайн механизмуудыг тусгаж өгсөн байвал үр дүнгээ өгч буй жишээг Австрали, Канад, ОХУ, Гана зэрэг улсын туршлага харуулж байна. Монгол улсын хувьд Ашигт малтмалын хуульд уул уурхайн компани орон нутгийн захиргаатай байгаль хамгаалах, уурхайн дэд бүтэц байгуулах, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр гэрээ байгуулан ажиллахыг үүрэг болгосон байдаг боловч энэ заалт нь төдийлэн хэрэгжиж ирээгүйг сүүлийн үеийн судалгаа харуулж байна.



2015 оны 04 сарын 22-ны өдөр, Өмнөговь аймаг, Даланзадгад сум

“Оюу толгой” компанийн хувьд Монгол улсын энэхүү хуулийн шаардлага, мөн үүнд нийцүүлсэн Хөрөнгө оруулалтын гэрээний үүргийнхээ дагуу орон нутгийн захиргаатай урт хугацааны итгэлцэлд суурилсан харилцаа, хамтын ажиллагааг бий болгож, баталгаажуулах зарчмынхаа дагуу урт хугацааны, иж бүрэн хамтын гэрээ хийх зорилт тавин ажилласан болно.

Хамтын ажиллагааны гэрээний зорилго: Өмнөговь аймаг болон түншлэгч сумдаас “Оюу толгой” төсөл болон “Оюу толгой” ХХК-ийн

бизнес, үйл ажиллагаанд бодитой дэмжлэг үзүүлэх, “Оюу толгой” компаниас “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гаар дамжуулан сайн дурын санхүүжилтийн дэмжлэг үзүүлэх байдлаар эрүүл мэнд, боловсрол, сургалт, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, байгаль орчин, соёлын өвийг хамгаалах, орон нутгийн бизнесийн хөгжлийг дэмжих зэргээр орон нутгийн нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах бөгөөд талуудын үр дүнтэй, ил тод, харилцан ач холбогдол бүхий хамтын ажиллагааг дэмжин хөгжүүлэх зорилготой.



ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН

АЛСЫН ХАРАА

*Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг
Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ*

ЭРХЭМ ЗОРИЛГО

*Өмнөговьчуудын сайн сайхан амьдралыг дэмжсэн хамтын
хөгжлийн санаачилгыг санхүүжүүлэгч сан байна*

ЭРХЭМЛЭХ ЗАРЧИМ

1. Авилгаас ангид байх
2. Хувийн ашиг сонирхлоос ангид байх
3. Үндэслэл, тооцоо баримт нотолгоонд суурилсан шийдвэр гаргах
4. Аливаа ялгаварлалгүйгээр нутгийн иргэдийн шударга оролцоог дэмжих, тэгш боломжоор хангах
5. Бүх төслүүд Сангийн эрхэм зорилготой уялдсан байх
6. Батлагдсан төслүүд тохиролцсон үр дүндээ хүрдэг байх

ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН

Хамтын ажиллагааны гэрээний хэрэгжилтийг хангах үүднээс “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” Төрийн бус байгууллагыг 2015 оны есдүгээр сарын 25-ны өдөр үүсгэн байгуулсан.

Уг гэрээний 8.3-т заасны дагуу “Оюу толгой” ХХК нь жил бүр таван сая ам.доллар, түүнтэй тэнцэх төгрөгийн санхүүжилтийг “Говийн оюу ХДС”-д олгодог. “Говийн оюу ХДС” нь эрүүл

мэнд, боловсрол, сургалт, хөдөлмөр эрхлэлт, орон нутгийн бизнесийн хөгжлийг дэмжих, байгаль орчин, соёлын өвийг хамгаалах зэргээр аймгийн болон Түншлэгч сумдын тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулахад чиглэгдсэн төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх, тэдгээрийг үр ашигтай, зүй зохистой удирдах зохион байгуулах зорилготой ажиллаж байна.

“ТОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-ГИЙН ЗАСАГЛАЛ САНГИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

Сангийн эрх барих дээд байгууллага болох Удирдах зөвлөл нь Өмнөговь аймаг, Ханбогд сум болон “Оюу толгой” компанийн төлөөлөл долоон хүний бүрэлдэхүүнтэй.

Сангийн хяналтын зөвлөлийн үүргийг хараат бус Итгэмжлэгдсэн төлөөлөгч хэрэгжүүлдэг бол Гүйцэтгэх захирлаар ахлуулсан гурван хүний бүрэлдэхүүнтэй ажлын алба өдөр тутмын үйл ажиллагааг эрхэлдэг.

Хуулийн хүрээнд байгуулсан дээрх бүтцээс гадна талууд Хамтын ажиллагааны гэрээний хүрээнд харилцан ойлголцол хамтын ажиллагааг дэмжих зохицуулах үүрэг бүхий Харилцааны хороог байгуулсан бөгөөд

Харилцааны хороо нь Удирдах зөвлөлд зөвлөмж өгөх үүрэгтэй. Харилцааны хороо 13 хүний бүрэлдэхүүнтэй, “Оюу толгой” компанийн төлөөлөл дөрвөн хүн, орон нутгийн төлөөлөл есөн хүн сонгогдон ажиллаж байна. “Оюу толгой” компанийн төлөөллийг Хангамж, хүний нөөц сургалт, байгаль орчин, орон нутгийн харилцаа гэсэн орон нутагтай илүү хамтран ажиллах шаардлагатай хэлтэс албадын төлөөлөл байдаг бол орон нутгаас сумдын удирдлага, аймгийн салбар хариуцсан хэлтэс агентлагийн удирдлага, иргэний нийгмийн байгууллагын төлөөллөөс бүрдэн ажиллаж байна.

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭНИЙ СЭДЭВЧИЛСЭН ХАВСРАЛТУУДЫН ДАГУУ “ТОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-Д ХҮЛЭЭН АВАХ ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН САНАЛЫН ЧИГЛЭЛ

Хамтын ажиллагааны гэрээ нь Өмнөговь аймаг, Ханбогд сум болон “Оюу толгой” компани хамтран ажиллахаар тогтсон дараах сэдэвчилсэн хавсралтуудтай. Үүнд:

- Усны менежмент
- Байгаль орчны менежмент
- Уламжлалт мал аж ахуй, бэлчээрийн менежмент
- Үндэсний түүх соёл ба аялал жуулчлал
- Нийгмийн суурь үйлчилгээ /эрүүл мэнд, боловсрол, сургалт/
- Нийгмийн дэд бүтэц ба хөрөнгө оруулалт

Эдгээр үндсэн чиглэлүүдээр Өмнөговь аймагт хэрэгжих төсөл, хөтөлбөрүүдийн саналыг хүлээн авч шалгаруулан нийгэмд илүү их үр өгөөж өгөх, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхүйц төсөл, хөтөлбөрүүдийг сонгон буцалтгүй санхүүжилт олгодог.

Харин Хамтын ажиллагааны гэрээний нөгөө нэг сэдэвчилсэн хавсралт нь “Орон нутгийн бизнес хөгжил ба бараа үйлчилгээ худалдан авалт” гэсэн сэдэвтэй бөгөөд энэ чиглэлийн хүрээнд орон нутгийн бизнесийг дэмжих харьцангуй ашгийн төлөө үйл ажиллагаа дэмжих шаардлагатай учир дээрх чиглэлүүдээс өөрөөр банкны хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр дэмжих зэрэг чиглэлээр хамтран ажиллаж байна.



УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ



Та бүхэнд “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гийн 2015-2016 оны үйл ажиллагааны тайланг танилцуулж байгаадаа туйлын таатай байна.

“Оюу толгой” ХХК нь “Эрдэс баялгаас эрдэм мэдлэг, ур чадвар, үнэт зүйлс бүтээлцэнэ” гэсэн алсын хараатай ажилладаг бөгөөд бид байгалийн эрдэс баялгаас эрдэм мэдлэг, ур чадвар, үнэт зүйлс бүтээлцэн, хувь нийлүүлэгчид болон оролцогч талууддаа үнэ цэн бий болгож, Монгол улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд урт хугацаанд хувь нэмэр оруулахаар зорин ажиллаж байна. Энэхүү алсын хараа, эрхэм зорилгынхоо хүрээнд орон нутгийн тогтвортой хөгжлийг хангахын тулд “Оюу толгой” ХХК нь Өмнөговь аймаг, тус аймгийн Ханбогд сумтай Хамтын ажиллагааны гэрээг 2015 оны дөрөвдүгээр сарын 22-ны өдөр байгуулсан юм. Гэрээгээ хэрэгжүүлэх гол бүтэц болсон “Говийн оюу

хөгжлийг дэмжих сан” ТББ-ыг мөн оныхоо есдүгээр сард байгуулснаас хойш Хамтын ажиллагааны гэрээгээр хүлээсэн үүргээ амжилттай биелүүлж, сангаараа дамжуулан 20 гаруй тэрбум төгрөгийн санхүүжилтийг 40 гаруй төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэхээр сангийн Удирдах зөвлөлөөр шийдвэрлэн амжилттай хэрэгжүүлж байна.

Өнгөрсөн хугацаанд Хамтын ажиллагааны гэрээний хүрээнд “Оюу толгой” компанийн санхүүжилттэй “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гийн хөрөнгө оруулалтаар Өмнөговь аймагт хүүхдийн шинэ цэцэрлэгүүд, хүн эмнэлэг, сургуулийн спорт заал зэрэг нийгмийн салбарын томоохон бүтээн байгуулалтууд бий болж, Хамтын ажиллагааны гэрээний сэдэвчилсэн хавсралт бүрээр тогтвортой хөгжлийн хөтөлбөрүүд амжилттай хэрэгжиж, говь нутгийн ард иргэдийн сайн сайхан амьдрал, орон нутгийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулж байгааг энэхүү тайлангаар та бүхэнд танилцуулж байгаадаа баяртай байна.

Бид орон нутгийн удирдлага, иргэдийн оролцоонд тулгуурлан тэдэнд хэрэгтэй, тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулж ажилласан маань зохих үр дүнгээ өглөө. Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд олсон ололтоо бататгаж, алдаа сургамжаасаа суралцан үйл ажиллагаагаа улам боловсролнгуй болгож, Өмнөговьчуудтайгаа хамтран говь нутгийн тогтвортой хөгжлийн төлөө илүү үр дүнтэй ажиллана гэдэгт итгэлтэй байгаагаа “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гийн Удирдах зөвлөл, Харилцааны хорооны гишүүдийн нэрийн өмнөөс болон хувиасаа илэрхийлэхэд таатай байна.

Итгэлцэлд суурилсан сайхан ирээдүйг Өмнөговьд бид хамтдаа бүтээнэ.

“Оюу толгой” ХХК-ийн гүйцэтгэх захирал,

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гийн Удирдах зөвлөлийн дарга


Стивэн Жонс

“ТОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”- ИЙН ЗАСАГЛАЛ

САНГИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

“Оюу толгой” ХХК, Өмнөговь аймаг, Ханбогд сумын хооронд байгуулсан Хамтын ажиллагааны гэрээний дагуу Талуудын оролцоог хангах зорилгоор сангийн бүтцэд Удирдах зөвлөл болон Харилцааны хороо гэх хоёр бүтэц бүрэлдэхүүнийг байгуулан

Өмнөговь аймагт нэн тэргүүний, хэрэгцээ шаардлагатай байгаа төсөл, хөтөлбөрүүдийг сонгон шалгаруулж, санхүүжилт олгох бүхий л үе шатанд орон нутаг болон “Оюу толгой” ХХК-ийн төлөөллийг багтаан ажиллаж байна.





САНГИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Сангийн Удирдах зөвлөл нь “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гийн эрх барих дээд байгууллага юм. Удирдах зөвлөл долоон гишүүнээс бүрдэнэ. Өмнөговь аймаг болон Ханбогд сум хамтран нэр дэвшүүлж, орон нутгийн гурван гишүүнийг, “Оюу толгой” ХХК-иас нэр дэвшүүлж ОТ-ХХК-ийн дөрвөн гишүүнийг томилсон.

Сангийн удирдлагыг сайжруулах болон Хамтын ажиллагааны гэрээнд нийцэж ажиллахад дэмжлэг үзүүлэх зорилгоор Сангийн дүрмийн дагуу удирдах зөвлөлд хараат бус Итгэмжлэгдсэн зөвлөх томилогдон ажиллаж байгаа.



Стефен Жонс
Удирдах зөвлөлийн дарга



Б.Баяр
Сангийн Итгэмжлэгдсэн зөвлөл



Х.Сугир
УЗ-ийн гишүүн



Н.Наранбаатар
УЗ-ийн гишүүн



Б.Эрдэнэ-Очир
УЗ-ийн гишүүн



Майкл Гавин
УЗ-ийн гишүүн



Д.Амарбаясгалан
УЗ-ийн гишүүн



Ш.Байгалмаа
УЗ-ийн гишүүн

ХАРИЛЦААНЫ ХОРОО

Сангийн Харилцааны хороо нь Хамтын ажиллагааны гэрээний дагуу байгуулагдсан Өмнөговь аймаг, “Оюу толгой” ХХК болон хамтран ажиллах орон нутаг дахь Түншлэгч сумдын аливаа хамтын ажиллагаанд хяналт тавих зорилготой бүтэц бүрэлдэхүүн юм.

Харилцааны хороо 13 гишүүнээс бүрдэнэ. Өмнөговь аймаг болон Ханбогд сум хамтран нэр дэвшүүлж орон нутгийн есөн төлөөлөгчийг томилж, “Оюу толгой” ХХК-иас нэр дэвшүүлж ОТ-ХХК-ийн дөрвөн гишүүнийг дараах байдлаар томилон ажиллаж байна.



Х.Батболд



Ж.Сүх-Эрдэнэ



Ө.Баянмөнх



Ү.Энхцацрал



У.Пүрэвтулга



Б.Дэндэвсамба



Г.Буянхүү



А.Оюунтуяа



В.Мөнхбат



Ш.Байгалмаа



Л.Удвал



Д.Амартүвшин



Н.Эрдэнэбаяр

“ГОВИЙН ОЮУ ХДС”-Д ХҮЛЭЭН АВАХ САНАЛЫН ЧИГЛЭЛ, ШАЛГУУР


САНХҮҮЖИЛТ ОЛГОХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Хамтын ажиллагааны гэрээний дагуу Талууд үүрэг амлалт хүлээсэн бөгөөд “Оюу толгой” ХХК нь нийгмийн дэд бүтэц, байгаль орчин, усны менежмент, үндэсний түүх соёл, уламжлалт мал аж ахуй, нийгмийн суурь үйлчилгээ, орон нутгийн бизнесийн хөгжлийг дэмжих, тэднээс бараа үйлчилгээ худалдах авах гэсэн долоон сэдэвчилсэн чиглэлээр Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулахаар харилцан тохиролцсон.

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан” нь иргэд, байгууллагуудаас дээр дурдсан нийгмийн дэд бүтэц, байгаль орчин, усны менежмент, үндэсний түүх соёл, уламжлалт мал аж ахуй, нийгмийн суурь үйлчилгээ

гэсэн зургаан чиглэлийн Өмнөговь аймагт хэрэгжих төсөл, хөтөлбөрийн санал хүлээн авч Харилцааны хороо болон Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, Өмнөговь аймагт нэн тэргүүний, хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, хөтөлбөрийг шалгаруулж санхүүжилт олгодог.

Орон нутгийн бизнес хөгжил, бараа үйлчилгээ худалдан авалтын чиглэлийн төслүүдэд санхүүжилт олгоходоо бид ХААН банктэй гэрээ байгуулж, бичил зээлийн үйлчилгээг хариуцуулснаар жил бүр бизнесээ шинээр эхлүүлэх болон өргөжүүлэх зорилготой Өмнөговь аймгийн бизнес эрхлэгчдэд 30 сая хүртэлх төгрөгийн нэг хувийн хүүтэй хөнгөлөлттэй зээл санал болгож, төслийн уралдаан зарлаж шалгаруулж байгаа.



АШГИЙН БУС НИЙГЭМД ЧИГЛЭСЭН САНАЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ШАЛГУУР

Удирдах зөвлөл, Харилцааны хороо болон “Говийн оюу хөгжлийг дэмжих сан” дараах шалгууруудаар төсөл, хөтөлбөрийн саналыг хянан үзэж, санхүүжүүлэх шийдвэр гаргана.

“ГОВИЙН ОЮУ ХДС”:

Санал хүлээн авах, бүртгэх, материалын бүрдэлд хяналт тавих

Санхүүжилтийн шалгуурын дагуу анхан шатны үнэнэлт хийх

- Бүрэн бөглөсөн саналын маягт
- Аудитаар шалгагдсан гурван жилийн санхүүгийн тайлан
- Иргэний үнэмлэх, байгууллагын гэрчилгээ
- Дэлгэрэнгүй хэрэгжүүлэлтийн хуваарь, бүтэц
- Тодорхой зардлын задаргаа
- Өмнөговь аймагт хэрэгжих
- Хэмжиж болохуйц үр өгөөж
- Шаардлагатай бусад бичиг баримт

ХАРИЛЦААНЫ ХОРОО:

Саналыг санхүүжилтийн удирдамжид нийцсэн эсэхийг хянах, нээлттэй хэлэлцүүлэг явуулж оноо өгч эрэмбэлэн зөвлөмжийн хамт Удирдах зөвлөлд хүргүүлэх

- Сангийн удирдамж, шалгуур, Хамтын ажиллагааны гэрээнд нийцсэн байдал
- Аймаг, хөгжлийн чиглэлүүдтэй уялдсан байдал
- Төслийн тогтвортой байдал, удирдлага, зохион байгуулалт
- ХДС-ийн зорилтот бүлэг болох хүүхэд залуучууд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, малчдыг дэмжсэн эсэх

УДИРДАХ ЗӨВЛӨЛ:

Харилцааны хорооны зөвлөмж болон үнэлэлтийг хянаж эцсийн дэмжих, эс дэмжих шийдвэр гаргах

- Гүйцэтгэх захирал Харилцааны хорооны үнэлсэн саналуудыг хэлэлцэх
- Төсөл, хөтөлбөрийн тогтвортой, бодит, аюулгүй байдлыг хянаж үзэх
- Харилцааны хорооны эрэмбэ болон зөвлөмжийг авч үзэх
- Хамтын ажиллагааны гэрээ, Санхүүжилтийн удирдамж, шалгуурт нийцсэн байдлыг хянах
- “Оюу толгой”, Өмнөговь аймаг, Ханбогд сумын хамтын ажиллагаанд үзүүлэх үр өгөөжийг авч үзэх

“ГОВИЙН ОЮУ ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ САН”-Д ХҮЛЭЭН АВАХГҮЙ САНАЛ

“Говийн оюу хөгжлийг дэмжих сан” нь дараах өргөдлийг хүлээн авч судлан үзэхгүй:

- Шашны, эсвэл улс төрийн байгууллагыг дэмжих зорилготой
- Өмнөговьос гадна хэрэгжих төсөл, хөтөлбөр
- Байгууллагын үйл ажиллагааны зардлыг хариуцах

- Хувь хүний аялал, эмчилгээний болон уралдаан тэмцээнд оролцох зардал
- Энэхүү санхүүжилт олгох журмаас ангид урьдчилан эхлүүлсэн төсөл
- Алдагдал нөхөх болон яаралтай санхүүжүүлэх төсөл




ХДС-Д ИРҮҮЛСЭН САНАЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Говийн оюу хөгжлийг дэмжих сан"-д төсөл, хөтөлбөр хүлээн авч санхүүжилт олгох үйл явцыг үндсэн таван үе шатанд хуваана.

- 1-р үе шат-ХДС-д санал ирүүлэх: Өмнөговь аймаг болон Түншлэгч сумдын эрх бүхий байгууллага, иргэд төсөл, хөтөлбөрийн саналаа ХДС-д хүргүүлж, ХДС-д санал хүлээн авах, бүртгэх маягтад гарын үсэг зурснаар баталгаажна.
- 2-р үе шат- ХДС-д ирүүлсэн саналыг хүлээн авч бүртгэх: ХДС-д ирүүлсэн саналыг хүлээн авч бүртгэх маягыг ашиглан бүртгэж баталгаажуулна. Ирсэн саналд ХДС-ийн Гүйцэтгэх захирал анхан шатны үнэлгээ хийж, төслүүдийг Харилцааны хороонд үнэлгээний хамт явуулна.
- 3-р үе шат- Харилцааны хороо ХДС-д ирүүлсэн саналыг эрэмбэлнэ: ХДС-д ирүүлсэн саналыг Сангийн санхүүжилтийн удирдамж, шалгуур, орон нутгийн тэргүүлэх чиглэл, хэрэгцээ шаардлага болон бусад бичиг

баримтад нийцүүлэн хянан үзэж, эрэмбэлэн сангийн Удирдах зөвлөлд зөвлөмжийн хамт хүргүүлнэ.

- 4-р үе шат- Удирдах ХДС-д ирүүлсэн саналыг баталж шийдвэр гаргана: Харилцааны хороогоор эрэмбэлэгдсэн саналуудыг хянан үзэж, ХДС-ийн Гүйцэтгэх захирал болон Харилцааны хорооны үнэлгээ, зөвлөмжийг харгалзан үзэж, Сангийн санхүүжилтийн удирдамж, шалгуур, ХДС-ийн стратеги, төлөвлөгөөнд нийцүүлэн санхүүжилтийн шийдвэр гаргана. Нэмэлт мэдээлэл шаардлагатай төслүүдийг Харилцааны хороо руу буцааж, нэмэлт мэдээллийг авч дахин хэлэлцүүлж эрэмбэлүүлнэ.
- 5-р үе шат- Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлнэ: Сангийн Удирдах зөвлөлөөс дэмжин санхүүжилт олгохоор баталсан төсөл, хөтөлбөрийн Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулан төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэн хяналт тавьж ажиллана.



ИРЭЭДҮЙ ХОЙЧ ҮЕИЙН ТӨЛӨӨ САН

“Говийн оюу ХДС” нь Ирээдүй хойч үеийн төлөө санг ХААН банктэй гэрээ байгуулан байршуулсан бөгөөд уг санг хадгаламж болон жижиг дунд бизнесийн дэмжих зээлийн хэлбэрээр байршуулсан. Сангаас ХААН банкинд 200,498,000 төгрөгийг зээлийн эх үүсвэрт, 200,498,000 төгрөгийг хадгаламж хэлбэрээр байршуулсан байгаа.

Хадгаламжийн нөхцөлийг дараах байдлаар тохиролцсон ба уг эх үүсвэрээр 10 жилийн дараа Өмнөговь аймагт томоохон хөрөнгө оруулалт хийнэ.

№	Хадгаламжийн дүн	Хүү	Хугацаа
1	200,498,000 төгрөг	16%	10жил

ХААН банк 200,498,000 төгрөгийг зээлийн эх үүсвэрийг иргэдэд бичил зээл хэлбэрээр олгох бөгөөд дараах нөхцөлтэй байна.

№	Олгох зээлийн хэмжээ	Хүү	Хугацаа
1	30,000,000 төгрөг хүртэл	12% / сарын 1%/	60 сар хүртэл

“ГОВИЙН ОЮУ-ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГ” ХӨТӨЛБӨР



Өмнөговь аймгийн “Саран ээж нийгэмлэг” төрийн бус байгууллагыг “Говийн оюу- Оюутны тэтгэлэг” хөтөлбөрийн Удирдах байгууллагаар сонгов.

Өмнөговь аймгийн ЗДТГ-ын нийгмийн хөгжлийн хэлтэс, “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гийн төлөөлөл болон “Саран ээж нийгэмлэг” төрийн бус байгууллагаас бүрдсэн сонгон шалгаруулах хороо байгуулагдаж,


2016 оны тэтгэлэгт хамрагдах оюутнуудыг сонгон шалгаруулсан.

“Говийн оюу-Оюутны тэтгэлэг” хөтөлбөрийн хүрээнд 2016 онд улсын болон магадлан итгэмжлэгдсэн сургуульд Өмнөговь аймагт дутагдалтай байгаа мэргэжлээр суралцаж байгаа 30 оюутанд 32,445,235 төгрөгийн тэтгэлэг олгосон.


УДИРДАХ ЗӨВЛӨЛӨӨС САНХҮҮЖҮҮЛЭХЭЭР БАТАЛСАН САНАЛУУД

2016 онд “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-д нийт 136 төсөл санал ирснээс Сангийн Удирдах зөвлөл Сангийн санхүүжилтийн удирдамж, шалгуур, Өмнөговь аймгийн нэн тэргүүний чиглэлтэй нийцсэн 26 төсөл, хөтөлбөрийн саналыг санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн.

“Говийн оюу хөгжлийн дэмжих сан”-гийн 2016 онд хүлээн авсан төсөл, хөтөлбөрийг чиглэлээр нь дараах байдлаар харуулж байна.



Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-гаас 2016 онд санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хуваарилалтыг дараах байдлаар харуулж байна.



САНГИЙН 2016 ОНД ӨМНӨГОВЬ АЙМАГТ ОРУУЛСАН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ



13 ТЭРБУМ ТӨГРӨГ

Нийгмийн дэд бүтэц-5

- Баян-Овоо сумын эмнэлэг: 10 ортой эмнэлгийн барилга угсралтын ажил хийв
- Ханбогд сумын сургууль цэцэрлэгийн цогцолбор: 640 хүүхдийн сургууль, 144 хүүхдийн цэцэрлэгийн барилга барина
- Даланзадгад сумын 2-р сургуулийн спорт заал: 15x43 метр талбайтай спорт заалны барилга угсралтын ажил хийв
- Сум дундын малын эрүүл мэндийн төв: Ханбогд, Баян-Овоо, Манлай, Цогтцэций сумын дундах малын эрүүл мэндийн төвийн барилга угсралтын ажил хийнэ
- Манлай сумын уурын зуух: Одоо байгаа уурын зуухны хүчин чадал хоёр дахин нэмэгдэж Манлай сумын 2400 гаруй хүний эрүүл амьдрах орчин нөхцөл бүрдэнэ.



367,1 САЯ ТӨГРӨГ

Байгаль орчны менежмент-3

- Ханбогд суманд мод үржүүлгийн газар байгуулах: Ханбогд сумын төлөвлөгөөнд суусан газар 10,000 навчит мод, 12,000 жимс, жимсгэний мод тарина
- Оюу хүлэмж: 2016-2020 оны хооронд жил бүр 50 хүнд 60 хувийн хөнгөлөлттэй хүлэмж олгоно
- Говийн ойн төгөл: Манлай сумын төлөвлөгөөнд суусан газар 2600 мод тарина.



393 САЯ ТӨГРӨГ

Уламжлалт мал аж ахуй-2

- Ариутгал-2016: 15 сумын 5417 өрхийн 4617 өвөлжөө, хаваржааг артгасан
- Тариа: Манлай суманд 0,25 га талбайг хашиж 54 өрхийн гишүүд эрдэнэшиш, малын тэжээлийн ургамал тариалах боломжтой болно.



683,5 САЯ ТӨГРӨГ

Үндэсний түүх соёл аялал жуулчлал -4

- Шар цав, Хүрдэт агуйн соёлын өвийг аялал жуулчлалтай хослуулан хамгаалах: 18,000 гаруй үлэг гүрвэлийн мөрийг хамгаалж геопаркийн тогтолцоог бий болгоно
- Манлайн музей: Хуучин музейг засварлаж үзмэрийн дөрвөн өрөөг тохижуулж шилэн хорготой болгож камержуулалтын ажил хийсэн
- Аялал жуулчлалын салбарын хөгжил, жуулчдыг татах сургалт, сурталчилгаа: Өмнөговь аймгийн талаар таван сэдвээр 8-10 цуврал кино бэлтгэж орос, япон, англи, хятад, солонгос хэлээр хөрвүүлэн гаргана
- Үндэсний өв соёл, мэдлэг ухааныг хүүхэд залууст өвлүүлэн үлдээх: Ханбогд сумын 11 ангийн 307 сурагчид сургалт хийнэ.



13,3 САЯ ТӨГРӨГ

Усны менежмент -1

- Нутгийн иргэдэд тулгуурласан усны чанарын хяналт үнэлгээ: Түншлэгч сумдын долоон сургуулийн сурагчдад хүрч ажиллан 15-20 үе тэнгийн сурагч багш бий болгоно.



743,5 САЯ ТӨГРӨГ

Нийгмийн суурь үйлчилгээ-11

- Хотын соёл: 18,000 иргэнд сургалт, нөлөөллийн ажил хийв
- Сургалт: 345 хүүхэд залуучуудад сургалт хийв
- Эрүүл малчин: 690 малчинд эрүүл мэндийн тусламжийн үйлчилгээ үзүүлэв
- Цахим сургалтаар сурагчдын мэдлэг чадварыг сайжруулах: Даланзадгад сумын 5-р сургуулийн мэдээлэл технологийн танхимыг тохижуулж 35 компьютер, ширээ сандал суурилуулна
- Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчны суурь судалгаа: Өмнөговь аймгийн нийт сумдаас судалгаа авч 90 ном, 30 зөвлөмж бүхий гарын авлага хэвлэгдэн гарна
- Хүний наймааны хохирогч болон шилжин суурьшигчдын эрхийг хамгаалах: 1000 ачааны тэрэгний жолооч, эмэгтэйчүүд, 500 гаруй сурагчдад сургалт хийж мэдээлэл өгч судмын мэргэжилтнүүдийг чадавхжуулна
- Миний гэр бүл: Аймгийн 15 сумын 1002 өрхийн 4622 иргэнийг сургалтад хамруулж загвар гэр бүл болгож иргэдийн гэр бүлийн үнэ цэнэ, ач холбогдлын талаарх мэдлэгийг дээшлүүлнэ
- Залуу манлайлагч: 15 сумын залуучуудаас судалгаа авч 3000 хүүхэд залуучуудад сургалт хийнэ
- Орон нутагт замын хөдөлгөөнд зөв соёлтой оролцох мэдлэг чадвар эзэмшүүлэх: Түншлэгч сумдын 240 сурагчид сургалт хийнэ
- Говийн бүсийн сэргээн засах үйлчилгээ: БОЭТ дээр Сэргээн засах үйлчилгээний тасаг бий болгож мэргэжлийн хоёр боловсон хүчин бэлтгэнэ
- Чадварлаг эмч: 33 камер суурилуулж нярайн тасгийг тохижуулж 250 эмч, сувилагчийг сургалтад хамруулна

ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРИЙН НЭР		БАТЛАГДСАН ДҮН
Нийгмийн дэд бүтэц		
1	Баян-Овоо сумын 10 ортой эмнэлэг	1,088,326,773
2	Ханбогд сумын сургууль цэцэрлэгийн цогцолбор	2,222,329,508
3	Даланзадгад сумын 2-р сургуулийн спорт заал	796,881,575
4	Ханбогд сумын сум дундын малын эрүүл мэндийн төв	1,465,288,608
5	Манлай сумын уурын зуух	1,090,110,360
Дэд дүн		6,662,936,824
Байгаль орчны менежмент		
1	Ханбогд сумын мод үржүүлгийн газар байгуулах	88,174,747
2	Бүх сумдын Оюу хүлэмж	150,000,000
3	Манлай сумын "Говийн ойн төгөл" хөтөлбөр	129,206,500
Дэд дүн		367,381,247
Нийгмийн суурь үйлчилгээ		
1	Даланзадгад сумын "Хотын соёл" хөтөлбөр	56,813,000
2	Бүх суманд хэрэгжих "Сургалт" хөтөлбөр	14,785,000
3	Ханбогд сумын "Эрүүл малчин" хөтөлбөр	100,000,000
4	Цахим сургалтаар сурагчдын мэдлэг чадварыг сайжруулах	49,450,000
5	Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчны суурь судалгаа	39,280,200
6	Хүний наймааны хохирогч болон цагаачдын эрхийг хамгаалах	34,215,524
7	"Миний гэр бүл" төсөл	47,322,720
8	Залуу манлайлагч	46,825,785
9	Орон нутагт замын хөдөлгөөнд зөв соёлтой оролцох мэдлэг чадвар эзэмшүүлэх	6,422,200
10	Говийн бүсийн сэргээн засах үйлчилгээ	164,608,800
11	Чадварлаг эмч	183,800,000
Дэд дүн		743,523,229
Уламжлалт мал аж ахуй, бэлчээрийн менежмент		
1	Ариутгал-2016	386,585,600
2	Тариа	3,000,000
Дэд дүн		389,585,600
Үндэсний түүх соёл, аялал жуулчлал		
1	Манлай сумын "Шар цав, Хүрдэт агуйн соёлын өвийг аялал жуулчлалтай хослуулан хөгжүүлэх"	413,000,000
2	Манлайн музей	36,297,700
3	Аялал жуулчлалын салбарын хөгжил- жуулчдыг татах сургалт, сурталчилгаа	200,000,000
4	Үндэсний өв соёл, мэдлэг ухааныг хүүхэд залууст өвлүүлэн үлдээх сургалт	34,165,000
Дэд дүн		683,462,700
Усны менежмент		
1	Нутгийн иргэдэд тулгуурласан усны чанарын хяналт, үнэлгээ	13,349,326
Дэд дүн		13,349,326
Бусад		
1	Хандив тусламж	200,498,000
2	Ирээдүй хойч үеийн төлөө сан	501,245,000
3	ХДС-ийн үйл ажиллагааны зардал	200,498,000
4	2015 онд хэрэгжсэн 25, 26-р цэцэрлэгийн үлдэгдэл	193,825,071
Дэд дүн		1,096,066,071
НИЙТ ДҮН		9,956,304,997




2015 ОНД ХЭРЭГЖСЭН НИЙГМИЙН ДЭД БҮТЭЦ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛҮҮД

ДАЛАНЗАДГАД СУМЫН 25, 26-Р ЦЭЦЭРЛЭГИЙН БАРИЛГА

25-р цэцэрлэгийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгч: "Хүннүгийн говь" ХХК

26-р цэцэрлэгийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгч: "Жи Жи Ай" ХХК



ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Даланзадгад суманд 2015 оны байдлаар сургуулийн өмнөх насны нийт 2,763 хүүхэд байснаас 1,958 хүүхэд цэцэрлэгт хамрагдаж 805 хүүхэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшиж чадахгүй гэртээ байсан. 2015 онд нийт долоон цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байсан бөгөөд эдгээр цэцэрлэгийн стандарт анги дүүргэлт 25 хүүхэд боловч нэг ангид 34-48 хүүхэд сурч хүмүүжиж байсан.

барилга угсралтын ажлыг "Жи Жи Ай" ХХК 2015 оны 8 дугаар сарын 24-өөс 2016 оны 2 дугаар сарын 1-ний хооронд хийж гүйцэтгэн улсын коммист хүлээлгэн өгснөөр улмаар 2016 он 4 дүгээр сарын 19-ний өдөр уг хоёр цэцэрлэгийн нээлтийн ёслол болж өдгөө үйл ажиллагаа жигдрэн хүүхэд багачуудын дуу цангинасан өргөө болж чаджээ.

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ

Өмнөговь аймгийн ЗДТГ-ын захиалгаар Даланзадгад сумын шинэ суурьшлын бүсэд байрлах 25-р цэцэрлэгийн барилга угсралтын ажлыг "Хүннүгийн говь" ХХК 2015 оны 8 дугаар сарын 24-өөс 2016 оны 1 дүгээр сарын 25-ны хооронд хийж гүйцэтгэн улсын коммист хүлээлгэн өгч, Даланзадгад сумын 1, 2-р багийн гэр хорооллын бүсэд байрлах 26-р цэцэрлэгийн


ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ

Даланзадгад сумын сургуулийн өмнөх боловсрол эзэмшиж чадахгүй байсан 805 хүүхдээс 349 нь шинээр баригдсан 25, 26-р цэцэрлэгт хамрагдан үе тэнгийнхэнтэйгээ сурч хүмүүжиж байна. Уг цэцэрлэгүүдэд орон нутгийн 67 хүн байнгын ажилтай болсон бөгөөд 349 хүүхдийн эцэг эх хөдөлмөр эрхлэх боломжтой болсон.

2016 ОНД БАТЛАГДАН ХЭРЭГЖСЭН НИЙГМИЙН ДЭД БҮТЦИЙН ТӨСЛҮҮД

БАЯН-ОВОО СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН БАРИЛГА

Баян-Овоо сумын эрүүл мэндийн төвийн барилга
угсралтын ажлын гүйцэтгэгч: “Суварган говь” ХХК



ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Баян-Овоо сумын хуучин эмнэлэг 1979 онд баригдсан бөгөөд 2014 онд үерт автан уг эмнэлгийн барилга муудсан байсныг Мэргэжлийн хяналтын газраас 2015 онд шалгаж эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх стандарт, шаардлага хангахгүй гэж тогтоосон. Уг эмнэлгийн барилга хуучирч үерт автан эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх байр гэхээсээ халдварт өвчин тархах, ялангуяа мөөгөнцрийн халдвар, өвчтөнөөс өвчтөнд халдвар тархах эрсдэлтэй барилга болсон байжээ. Үндэсний эрүүл мэндийн үйлчилгээний стандарт 2000-15000 иргэнд дунджаар 15-30 ортой, эмч, сувилагч, эх баригч, туслах ажилчидтай эмнэлэг байх ёстой гэж заасан байдаг. Баян-Овоо сумын иргэний тоо 2016 оны байдлаар 1737 байсан учир 10 ортой эмнэлэг барих нь зохистой гэж мэргэжлийн байгууллага үзэв.

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ

Өмнөговь аймгийн ЗДТГ-ын захиалгаар Баян-Овоо сумын эрүүл мэндийн төвийн барилга угсралтын ажлыг “Суварган говь” ХХК 2016 оны 5 дугаар сарын 20-ноос 10 сарын 18-ны хооронд хийж гүйцэтгэн улсын коммист хүлээлгэн өгснөөр өдгөө үйл ажиллагаа нь жигдрэн Баян-Овоо сумын эмч, сувилагч ажилчид тав тухтай, шинэ эмнэлэгт ажиллан өвчтөн хүлээн авч эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж байна.

ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ

Стандартад нийцсэн эмнэлэгтэй болсноор Баян-Овоо сумын эмч, ажилчид эрүүл мэндийн үйлчилгээг иргэдэд саадгүй, чанартай хүргэж чаддаг болсон. Эмч нар иргэдэд эрүүл мэндийн сургалт, боловсрол олгох, урьдчилан сэргийлэх үзлэг, халдварт өвчний хяналт, өвчний тархалтыг үнэлэх, амбулаторийн үзлэг, мэс ажилбар, оношилгоо, гадуур үзлэг хийх, яаралтай тусламж, нөхөн сэргээх эмчилгээ хийх боломжтой болсон нь Өмнөговь аймгийн эрүүл мэндийн салбарын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан билээ.



ДАЛАНЗАДГАД СУМЫН 2-Р СУРГУУЛИЙН ЗААЛНЫ БАРИЛГА

Даланзадгад сумын 2-р сургуулийн
заалны барилга

угсралтын ажлын гүйцэтгэгч:
"Говийн өгөөж" ХХК



Гурвантэс



ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Даланзадгад сумын 2 дугаар сургуульд 2015 оны байдлаар нийт 768 хүүхэд суралцаж байсан. Тус сургуулийн спорт заал нь 6x12 харьцаатай, зөвхөн гар бөмбөгийн заалны анхан шатны шаардлагыг хангасан биеийн тамирын хичээл заах орчин үеийн шаардлага стандартыг хангаагүй, хувцас солих өрөөгүй, төрөл бүрийн секц дугуйлан хичээллүүлэх боломж бүрдээгүй зэргийг үндэслэн аймгийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2016 оны үндсэн чиглэлд 2-р сургуульд спорт заалны барилга шинээр барихаар төлөвлөсөн.

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ

Өмнөговь аймгийн ЗДТГ-ын захиалгаар Даланзадгад сумын 2-р сургуулийн заалны барилга угсралтын ажлыг "Говийн өгөөж" ХХК 2016 оны 8 дугаар сарын 15-наас 11 дүгээр сарын 21-ний хооронд хийж гүйцэтгэн улсын коммист хүлээлгэн өгснөөр 2-р сургуулийн сурагчид стандартад нийцсэн хувцас солих өрөөтэй иж бүрэн шинэ заалтай болж биеийн тамирын хичээл, дугуйлан секцэндээ идэвхтэй хамрагдаж байна.

ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ

Стандартад нийцсэн спорт заалтай болсноор 2-р сургуулийн сурагчид чөлөөт цагаараа төрөл бүрийн спортын секц, дугуйланд хичээллэн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлж байна. Сургуулийн захиргаанаас хүүхэд хөгжүүлэх биеийн тамирын олон талт арга хэмжээ зохион байгуулах боломжтой болсон.

2016 ОНД БАТЛАГДАН ХЭРЭГЖИЖ БАЙГАА НИЙГМИЙН ДЭД БҮТЦИЙН ТӨСЛҮҮД

ХАНБОГД СУМЫН СУРГУУЛЬ ЦЭЦЭРЛЭГИЙН КОМПЛЕКС

Ханбогд сумын сургууль цэцэрлэгийн цогцолборын барилга угсралтын ажлын гүйцэтгэгч: Гүйцэтгэгч, сонгон шалгаруулж байгаа



ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

2015 оны байдлаар Ханбогд суманд 5200 иргэн оршин сууж байсан бөгөөд үүнээс 1500 нь 3-18 насны хүүхэд байсан гэсэн тоо баримт байгаа бөгөөд 2020 он гэхэд Ханбогд сумын иргэдийн тоо 14000 хүрнэ гэсэн төлөвтэй байна. Улсын хэмжээнд ерөнхий боловсролын сургуулийн анги дүүргэлт 20-30 хүүхэд, цэцэрлэгийн анги дүүргэлт 30 хүүхэд байна гэсэн стандарттай боловч Ханбогд суманд

360 хүүхдийн хүчин чадалтай сургуульд 900 хүүхэд сурч байна. Нэг ангид 40 хүүхэд байна. 300 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгт 420 хүүхэд хамрагдаж байна. 208 хүүхэд цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байна.

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ

Өмнөговь аймгийн ЗДТГ-ын захиалгаар “Говь гурван зам” ХХК Ханбогд сумын сургууль цэцэрлэгийн цогцолборын барилгын зураг төсөв боловсруулах ажлыг 2016 оны 8 дугаар сарын 24-нөөс 10 дугаар сарын 3-ны хооронд хийж гүйцэтгэн захиалагчид хүлээлгэн өгсөн. Одоогоор уг төслийн барилга угсралын ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил явагдаж байна.


ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ

Хүүхэд сурч, өсөх таатай орчныг бий болгосноор орон нутгийн нийгмийн суурь үйлчилгээг сайжруулж Ханбогд сумын сургалтын чанар, хүртээмж дээшилж, боловсролын систем үнэмлэхүйц сайжран хөгжинө. Уг төсөл хэрэгжсэнээр 640 хүүхдийн сургууль, 144 хүүхдийн цэцэрлэгийн барилга баригдаж 70-80 хүний ажлын байр бий болно.



СУМ ДУНДЫН МАЛЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

Сум дундын малын эрүүл мэндийн төвийн барилга угсралтын ажлын гүйцэтгэгч: “Билэгт багана” ХХК



ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

2015 онд Ханбогд сумын Засаг даргын санаачилгаар Ханбогд сумын мал аж ахуйн тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг боловсруулан иргэд, малчдаар хэлэлцүүлэн баталсан. Уг хөтөлбөрийн хүрээнд малын эрүүл мэндийн нэгдсэн төвийг байгуулж, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх, шаардлагатай тоног төхөөрөмж, програм хангамж бусад материалаар хангах Сум дундын малын эрүүл мэндийн төвийн барилгыг бариулах асуудлыг дэвшүүлж Ханбогд, Манлай, Баян-Овоо, Цогтцэций сумдын иргэдийн дэмжлэгтэйгээр сум дундын нэгдсэн малын эмнэлэг барих зөвшилцөлд хүрсэн.

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ

Өмнөговь аймгийн ЗДТГ-ын захиалгаар “Эн Си Си Эс” ХХК Сум дундын малын эрүүл мэндийн төвийн барилгын зураг төсөв боловсруулах ажлыг 2016 оны 8 дугаар сарын 22-ноос 2017 оны 1 дүгээр сарын 27-ны хооронд хийж гүйцэтгэн захиалагчид хүлээлгэн өгсний дагуу тендер зохион байгуулж “Билэгт багана” ХХК-ийг гүйцэтгэгчээр сонгон шалгаруулав.

ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ

Малын эрүүл мэндийн нэгдсэн үйлчилгээг Ханбогд, Манлай, Баян-Овоо, Цогтцэций сумдын малчдад үзүүлж, хүртээмжийг нэмэгдүүлж, малчдын малын эрүүл мэнд, чанарын талаарх мэдлэгийг дээшлүүлнэ, мал маллагааны удирдлагыг сайжруулж дөрвөн суманд эмнэлэг барихад гарах давхардсан зардлыг багасгана. Улмаар мал эмнэлэг, үржүүлэг, лабораторийн үйлчилгээг үзүүлж, хүнсний аюулгүй байдлын талаарх ойлголтыг нэмэгдүүлнэ.

МАНЛАЙ СУМЫН УУРЫН ЗУУХНЫ БАРИЛГА

Манлай сумын уурын зуухны барилга угсралтын ажлын гүйцэтгэгч: Сонгон шалгаруулж байгаа



ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Манлай сумын одоо байгаа уурын зуух 330 хүүхдийн хичээлийн байрнаас 33 метр, 125 хүүхдийн цэцэрлэгээс 17 метр, 77 хүүхдийн дотуур байрнаас 28 метрийн зайд байрлан үйд ажиллагаа явуулж олон жилийн турш өсвөр залуу үеийн болон 100 гаруй айл өрхийг нүүрс үнс, уурын зуухны утаа, агаарын бохирдолд автуулсаар ирсэн. Иймд Манлай сумын уурын зуухны барилгыг шинэ байрлалд шилжүүлэхээр төлөвлөж шаардлагатай судалгаа шинжилгээ, зураг төсөв боловсруулах ажлыг хийж гүйцэтгэсэн.

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ

Уг төсөл Сангийн 2016 оны 11 дүгээр сарын 24-ний хурлаар батлагдсан бөгөөд одоогоор гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажил явагдаж байна.

ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ

Уурын зуухны барилгыг нүүлгэн шинээр бариулж, халаалтын төвлөрсөн системийг ашиглалтад оруулснаар одоо ашиглагдаж байгаа хүчин чадлаас хоёр дахин нэмэгдэж айл өрхүүд халаалтад бүрэн холбогдох боломжтой болно. Ингэснээр Манлай сумын иргэдийн эрүүл, тав тухтай амьдрах орчин, нөхцөл бүрдэнэ.



2016 ОНД БАТЛАГДАН ХЭРЭГЖИЖ БАЙГАА БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ, ХАМГААЛАЛТЫН ХӨТӨЛБӨРҮҮД

ХАНБОГД СУМЫН МОД ҮРЖҮҮЛГИЙГ ГАЗАР

Ханбогд сумын мод үржүүлгийн газар
байгуулах хөтөлбөрийн хэрэгжүүлэгч:
“Говийн газар шороо” ТББ



ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Дэлхийн уур амьсгалын өөрчлөлт, хүний зохисгүй үйл ажиллагааны нөлөөгөөр манай оронд цөлжилт, хөрсний элэгдэл ихэсч, усны нөөц, биологийн төрөл зүйл хомсдох, байгалийн гамшгийн давтамж нэмэгдэх асуудал үүсч байгаа нь Ханбогд суманд мэдрэгдэж цөлжилт ихээр явагдах болсон. Уг асуудлыг шийдэхийн тулд ойжуулалтын ажил хийх зайлшгүй шаардлагатай байсан.

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ


Уг төслийн хүрээнд Ханбогд сумын ЗДТГ-аас нэр заасан, Ханбогд сумын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан таван га ногоон байгууламжийн талбайд 10,000 навчит мод, гурван зүйлийн жимс жимсгэний 12,000 мод тарьж мод үржүүлгийн газар байгуулан ойжуулах ажлыг Ханбогд сумын “Говийн газар шороо” ТББ 2016-2019 оны хооронд хийж гүйцэтгэхээр ажиллаж байна.

ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ

Байгаль орчны мэдлэгийг оюутан, сурагч, орон нутгийн иргэдэд олгох, тэднийг мод тарих, арчлахад сургаж экологийн тэнцвэрийг хамгаалах, цөлжилт болон хуурайшилттай тэмцэх, бичил цаг уурын таатай нөхцөлийг бүрдүүлэх, бэлчээрийн даац нэмэгдэж малчид бэлчээрээ зөв зохистой ашиглах боломжийг нээж өгнө.

ОЮУ ХҮЛЭМЖ

Бүх суманд хэрэгжиж буй “Оюу” хүлэмж хөтөлбөрийн хэрэгжүүлэгч: Өмнөговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар



ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

2015 оны байдлаар Өмнөговь аймгийн хэмжээнд 15 суманд 145 ширхэг, 13340 ам метр талбайд хүлэмжийн тариалан эрхэлж байна. Аймгийн хэмжээнд 162,8 га талбайд төмс, хүнсний ногоо тариалж 1400 гаруй тн ургац хураан авсан нь нийт хүн амын төмс хүнсний ногооны хэрэгцээний 35-40 хувь, хүлэмжийн ургац өрхийн хэрэгцээээс хэтрэхгүй байгаа нь цаашид хамгаалалттай хөрсний тариалалтыг нэмэгдүүлж эрчимжүүлэн орон нутгийн баталгаат хүнсний ногоогоор хангах шаардлагатай байгаа.

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ

“Оюу” хүлэмж хөтөлбөр нь 2016-2026 он хүртэл хэрэгжих бөгөөд Өмнөговь аймгийн тариаланч иргэдэд зориулагдсан энэхүү төслийн хүрээнд 15 сумын 50 хоршоо, 50 тариаланч хамрагдана. 15 сумын газар тариалан эрхэлдэг иргэнд хүлэмж олгож, хүлэмжийн нийт үнийн

дүнгийн 40 хувийг эргэн төлөлттэй байдлаар буцаан авч дараагийн жилдээ дахин иргэдэд хүлэмж нийлүүлэх замаар газар тариалан эрхэлдэг иргэдийн амьжиргааг дээшлүүлж, өрхийн орлогыг нэмэгдүүлэх ажил хийж байгаа. 2016 онд 13 сумын 50 иргэнд хүлэмж олгож, 40 хувийн эргэн төлөлтийг гэрээ байгуулан хоёр хуваан төлүүлж байгаа. Уг эргэн төлөлтийг эргэлтийн санд байршуулж байгаа бөгөөд “Оюу” хүлэмж хөтөлбөрийн 2017 оны ажил 10 дугаар сард эхэлнэ.


ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ

Өмнөговь аймгийн хэмжээнд хүлэмжийн тариалалтыг 4200 ам метр талбайгаар нэмэгдүүлж нарийн ногооны ургацыг 20 тонноор нэмнэ. Жил бүр шинээр 50 ажлын байр бий болж, 50 өрхийн орлого нэмэгдэнэ.



ГОВИЙН ОЙН ТӨГӨЛ

Манлай сумын “Говийн төгөл”
хөтөлбөрийн хэрэгжүүлэгч: “Бат цайз”
хоршоо



ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Манлай суманд элсний нүүдэл, уур амьсгалын өөрчлөлт, цөлжилт сүүлийн 10 жил ихээр мэдрэгдэж усны нөөц олдоц багасч биологийн төрөл зүйл хомсдож байгалийн тэнцвэр ихээр алдагдсан учир цөлжилт, элсний нүүдлийг намжаах зорилгоор ойжуулалтын ажил хийх зайлшгүй шаардлага тулгарсан.

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ

Уг төслийн хүрээнд Манлай сумын ЗДТГ-аас нэр заасан, сумын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан хоёр га ногоон байгууламжийн талбайд 1-3 настай 2600 мод тарих ажлыг Манлай сумын “Бат цайз” хоршоо 2016-2018 оны хооронд хийж гүйцэтгэхээр ажиллаж байна. Уг хөтөлбөрийн хүрээнд одоогийн байдлаар бүх оногдсон талбайг хашаажуулж, 2600 модны нүх ухаж худаг гаргах ажлыг хийж гүйцэтгээд байна.

ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ

Төсөл хэрэгжсэнээр 2600-3000 мод тарьж, экологийн тэнцвэрийг хамгаалах, цөлжилт болон хуурайшилттай тэмцэх ажилд үнэтэй хувь нэмэр оруулна. Түр болон байнгын 20 хүн ажлын байртай болж, Манлай сумын иргэдийн эрүүл мэндэд эергээр нөлөөлнө.


2016 ОНД БАТЛАГДАН ХЭРЭГЖСЭН НИЙГМИЙН СУУРЬ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРҮҮД

ХОТЫН СОЁЛ

Даланзадгад сумын Хотын соёл хөтөлбөрийн хэрэгжүүлэгч: Өмнөговь аймгийн насан туршийн боловсролын төв



Гурвантэс



ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Даланзадгад суманд сүүлийн жилүүдэд олон бүтээн байгуулалт хийгдэж өнгө үзэмж сайжирч, хотжиж байгаа боловч иргэдийн бие биенээ хүндэтгэх хүндэтгэл, хүний хийж бүтээснийг хайрлан хамгаалах, орчноо цэвэр цэмцгэр байлгах сэтгэл дутмаг байгаа учир хотын өнгө үзэмж хүний үйл хөдөлгөөнтэй салшгүй уялдаатай байдгийг ухамсарлуулах зайлшгүй шаардлага байсан.

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ

2016 оны 7 дугаар сарын 6-наас 12 дугаар сарын 31 хүртэл эерэг харилцаа, хандлага хэвшүүлэх иргэний эрх үүргийн мэдлэг, хоггүй орчин бүрдүүлэх, хогийг зохистой хаяж, бусдын хийж бүтээснийг хайрлан хамгаалах, эрүүл амьдрах, замын хөдөлгөөнд соёлтой, аюулгүй байдлыг хангаж оролцох зэрэг хотын соёлд

суралцуулах сургалт, нөлөөллийн ажиллагааг зохион байгуулж Даланзадгад сумын нийт иргэдийн 80 хувь буюу 18,000 иргэнд хүрч ажилласан.


ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ

Хотын соёл хөтөлбөрийн хүрээнд 332 цагаар 108 удаа сургалт зохион байгуулж 3991 хүнийг, олон нийтийн нөлөөллийн үйл ажиллагааг 10 удаа зохион байгуулж 995 хүн, нийт 4986 хүнд шууд хэлбэрээр хүрч ажиллан шууд бус хэлбэрээр мэдээллийн самбар, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, товхимол болон бусад тараах материалаар дамжуулан нийт 18,000 хүнд хүрч ажиллан хотын соёлыг түгээж чадсан. Түүврийн аргаар 302 хүнээс судалгаа авч үр дүнг дүгнэхэд 92 хувь нь хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж иргэдэд хүрч ажиллаж чадсан гэж үнэлсэн.



СУРГАЛТ

Бүх суманд хэрэгжсэн “Сургалт” хөтөлбөрийн хэрэгжүүлэгч: “Оюуны өргөө Ханбогд” ТББ



ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Сумын иргэд, залуучууд, хөдөлмөрчдийн боловсрол болон чадварыг тогтвортой хөгжүүлэх байгууллагууд орон нутагт цөөн байдаг. Ханбогд сумын залуучуудын мэдлэгийг дээшлүүлэх, хувь хүний хөгжлийг дэмжих сургалтын суурь боломж, нөөц хангалтгүй байна, тиймээс хувь хүний хөгжлийг дэмжих сургалт, семинар зохион байгуулах зайлшгүй шаардлагатай байгаа.

ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ

Сургалт хөтөлбөрийн хүрээнд 15 сумын нийт 345 хүн хамрагдсан бөгөөд долоон сэдвээр хувь хүний сургалт хийж иргэдийн мэдлэг боловсролыг дээшлүүлж өөрийгөө хөгжүүлэх, мэдлэг чадвараа дээшлүүлэх хүсэл эрмэлзэлтэй болгож хөтөлбөрт хамрагдсан нийт иргэдийн судалгаанаас харахад 95 хувь нь сургалт үр дүнтэй байсан гэсэн үр дүн гарсан.


ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ

2016 оны 7 дугаар сарын 1-нээс 9 дүгээр сарын 27-ныг хүртэл Өмнөговь аймгийн 15 суманд хувь хүний хөгжлийн тухай мэдлэг мэдээлэл түгээж, нийт сумдын иргэд, залуучууд, төрийн албан хаагчдад хүрч ажиллан хувийн хөгжил, харилцааны соёл, илтгэх урлаг, санаагаа оновчтой илэрхийлэх арга, цаг төлөвлөлт, багаар ажиллах чадвар болон манлайлал гэсэн сэдвүүдээр сургалт зохион байгуулсан.

2016 ОНД БАТЛАГДАН ХЭРЭГЖИЖ БАЙГАА НИЙГМИЙН СУУРЬ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРҮҮД

ЭРҮҮЛ МАЛЧИН

Ханбогд сумын “Эрүүл малчин” хөтөлбөрийн хэрэгжүүлэгч: Ханбогд сумын Сум дундын эмнэлэг



ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Ханбогд сумын нийт хүн амын 38 хувь нь малчин, нийт өрхийн 40 гаруй хувь нь малтай. Ханбогд, Баян-Овоо, Даланзадгад, Манлай сумын малчдын эрүүл ахуйн нөхцөл, эрүүл мэндийн байдлын судалгаанд хамрагдсан 10 малчин тутмын долоо нь өвдсөн үедээ эмнэлгийн тусламж үйлчилгээ аваагүй, өөрөө эмчилсэн, нийт малчдын 20 хувь нь суурин газраас алслагдмал оршин суудаг учраас эмнэлгийн тусламж үйлчилгээ авч чадаагүй хэмээсэн байна.

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ

2016 оны 7 дугаар сарын 20-ноос 10 дугаар сарын 10-ныг хүртэл Ханбогд сумын Сум дундын эмнэлэгт 21 төрлийн багаж тоног төхөөрөмж худалдан авч 23 эмч, эмнэлгийн ажилчдад төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны сургалтыг хийж одоогоор Ханбогд сумын төвөөс алслагдсан малчин иргэдэд эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх ажил явагдаж байгаа.

ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ

Энэхүү хөтөлбөр хэрэгжсэнээр сум дундын эмнэлэг явуулын үзлэг оношилгоо хийх 21 төрлийн 31 тоног төхөөрөмжтэй болсон учир малчдад үзүүлэх эрүүл мэндийн явуулын үйлчилгээний чанар хүртээмж сайжирсан. Эмнэлгийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа, байнгын бэлэн байдал хангагдаж эмч мэргэжилтнүүдийн багаж тоног төхөөрөмжтэй ажиллах мэдлэг, ур чадвар дээшилсэн. Өвчний эрт илрүүлэлтийн үзүүлэлт, оношилгооны түвшин дээшилж, амьдралын буруу хэв маягаас үүдэлтэй өвчлөл, эндэгдлээс сэргийлэх талаарх мэдлэг нэмэгдсээр байна.



ЦАХИМ СУРГАЛТААР СУРАГЧДЫН МЭДЛЭГ ЧАДВАРЫГ САЙЖРУУЛАХ

Цахим сургалтаар сурагчдын мэдлэг чадварыг сайжруулах хөтөлбөрийн хэрэгжүүлэгч:
Даланзадгад сумын 5-р сургууль Гүйцэтгэгч: “Хос могойн чуулган” ХХК



Гурвантэс

Сэврэй

Булган

Ханхонгор

Цогт-Овоо

Манлай

Даланзадгад

Цогтэций

Баяндай

Баян-Овоо

Ханбогд

Ноён

Хурман

Номгон

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Мэдээлэл технологийн салбар хөгжиж буй энэ үед Даланзадгад сумын 5-р сургуулийн захиргаа сурагчдынхаа мэдлэг боловсролд анхаарч ур чадвартай, компьютерийн өргөн мэдлэгтэй боловсон хүчин бэлтгэх зорилгоор энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэн уг төслийг хэрэгжүүлэх санал ирүүлсэн.

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ


Даланзадгад сумын 5-р сургуулийн хүүхдүүд мэдээлэл технологийн хичээлд орохдоо тус бүр өөрт хуваарилагдсан компьютер дээр хичээллэж, чанартай боловсрол эзэмшүүлэх зорилгоор 35 компьютер, компьютерийн ширээ, сандал, ухаалаг самбар, проектер худалдан авч мэдээлэл зүйн кабинетийг тохижуулах ажлыг хийж байгаа. Одоогоор танхим тохижуулах эд хогшил захиалан худалдан авах ажил явагдаж байгаа.

ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд нэг ангийн бүх сурагч нэгэн зэрэг хичээл зааж болохуйц компьютер ширээ, сандал, ухаалаг самбар бүхий танхимын тохижилтын ажил хийгдэнэ. Хүүхдүүдийн хичээлд хандах хандлага өөрчлөгдөж, мэдээ мэдээллийг шуурхай авч, компьютер дээр бүрэн ажиллаж сурах боломж бүрдэнэ.

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ, БАЙГАЛЬ ОРЧНЫ СУУРЬ СУДАЛГАА

Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчны суурь судалгаа хөтөлбөрийн хэрэгжүүлэгч: Бүтээлч үйлдвэрлэл, инновацийн төв, ТББ



ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Өмнөговь аймагт хэрэгжиж буй нийгмийн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт, иргэдэд үзүүлж байгаа төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг тодорхойлж иргэд, байгууллага, аж ахуй нэгжүүдийн хамтын ажиллагаа болон оролцоог нэмэх арга зүйг тодорхойлоход чухал шаардлагатай үндсэн судалгааг хийж, аймгийн хэтийн төлөвлөгөөг боловсруулах үндэс суурь тавигдах юм.

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ

Өмнөговь аймгийн 15 сумын 15 болон түүнээс дээш насны иргэдээс судалгаа авч таван талт арга ашиглан сумдын рейтинг тогтоож, сумдын санхүү, дэд бүтэц, хүн, нийгэм, байгаль орчны капиталаас хамааруулан үнэлэх арга зүй, үнэлгээний харьцуулсан үзүүлэлт боловсруулж програмчлах ажил хийж байгаа.

ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨХ

Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчны суурь судалгааны тайлан бүхий 90 ном хэвлэгдэн гарна. Уг тайлангаас гарсан үр дүнг багцлан програмчилж радар хэлбэртэй график гарган нэгдсэн тайланг мэдээлэл болгон мэдээллийн бааз бүрдүүлж, сум болон аймгийн Засаг даргын Тамгын газрын мэргэжилтнүүдэд танилцуулж сургалт хийнэ. Судалгааны тайланг хялбаршуулан 30 ширхэг зөвлөмж бэлтгэн гарна.




ХҮНИЙ НАЙМААНЫ ХОХИРОГЧ БОЛОН ШИЛЖИН СУУРЬШИГЧДЫН ЭРХИЙГ ХАМГААЛАХ

Хүний наймааны хохирогч болон шилжин суурьшигчдын эрхийг хамгаалах хөтөлбөрийн хэрэгжүүлэгч: Монгол Улс дахь Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага



Гурвантэс



ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Сүүлийн жилүүдэд уул уурхай болон бусад холбогдох эдийн засгийн боломжуудыг дагасан дотоодын цагаачдын нүүдэл Өмнөговь болон Дорноговь аймагт ихэссэн нь аймгийн нутгийн удирдах байгууллагыг эмзэг бүлгийн иргэдээ хамгаалахад бодлогын хувьд хүндрүүлж байгаа бөгөөд хүний наймааны эрсдэлийг ихэсгэж байна. Тиймээс энэ асуудлаар мэдлэг мэдээлэл олгох сургалт, сурталчилгааны ажил хийх зайлшгүй шаардлагатай байна.

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ

Хөтөлбөр 2016 оны 1 дүгээр сараас 2017 оны 1 дүгээр сар хүртэл хэрэгжих бөгөөд Сан болон Монгол Улс дахь Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллагын хамтарсан санхүүжилттэй хэрэгжиж, хүний наймаанд өртөх магадлал бүхий 1000 эмэгтэй болон ачааны машины жолооч, хамгийн багадаа 500 ахлах


сургуулийн сурагчдыг зорилтот бүлэг болгон хамгаалалтад авна. “Говийн оюу ХДС”-гаас авах санхүүжилт эдгээр хүмүүсийг хамгаалах, БЗХӨ-өөс урьдчилан сэргийлэх ажилд зориулагдаж байгаа.

ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨХ

Монгол улсын хэмжээнд хүний наймааны хохирогч болж болзошгүй иргэдийг хамгаалж хяналтдаа авах гол зорилгын дор 1000 эмэгтэй, ачааны машины жолооч, Ханбогд, Баян-Овоо, Манлай, Цогтцэций сумын уул уурхайн олборлолт явуулдаг байгууллагуудад мэдлэг мэдээлэл олгоно. Аймгийн хэмжээнд хүний наймааны эсрэг баримтлах стандартчилсан чиг бодлоготой болж Өмнөговь аймаг болон Дорноговь аймаг хүний наймаа, албадан хөдөлмөр эрхлэлт, цагаачдын эрхийн тухай мэдээлэл, баазтай болсон байна.

МИНИЙ ГЭР БҮЛ

“Миний гэр бүл” хөтөлбөрийн хэрэгжүүлэгч:
“Говийн ухаан” төрийн бус байгууллага



ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой хүн амын хөдөлгөөн ихэссэн зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалан гэр бүл салалт ихэсч, хараа хяналтгүй хүүхдийн тоо нэмэгдэж, гэмт хэрэгт холбогдох, хохирох, эрх нь зөрчигдөх эрсдэл бий болоод байна. Аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн сүүлийн дөрвөн жилийн харьцуулсан судалгаанаас үзэхэд жилд дунджаар 200 гэр бүл гэрлэлтээ бүртгүүлж, 72 гэр бүл салсан байна. Иймээс гэр бүлийн үнэ цэнийг хүүхэд, эцэг эхэд ойлгуулж загвар өрх бий болгож иргэдийг үлгэр дууриалтай болгох нийгмийн нэн тэргүүний хэрэгцээ шаардлага байна.

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ

2016 оны 1 дүгээр сараас 6 дугаар сар хүртэл Өмнөговь аймгийн 15 сумын иргэдэд гурван шаттай гэр бүлийн сэдэвтэй сургалт хийж гэр бүлийн гишүүдийг 35 чадамжинд сургаснаар гэр

бүлийн үнэ цэнийн тухай мэдлэг мэдээлэлтэй болж, эцэг эхчүүд хүүхдүүдтэйгээ хамт хөгжих юм. Одоогийн байдлаар 1-р үе шатны ажил явж байгаа бөгөөд 15 сумын 21 сургуульд ажиллаж, 10-14 настай хүүхэдтэй 1002 өрхийн 4622 хүнийг хамруулахаар сонгон авч анхан шатны судалгаа хийж, сургалтын ажлаа эхлүүлсэн байгаа.


ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ

Төсөлд хамрагдсан 1000 өрхийн 400-5000 иргэн гэр бүлийн хөгжлийн 35 чадамжийг эзэмшиж, зөв зан үйл төлөвшсөн байна. Аймгийн хэмжээнд гэр бүл салат 2-4 хувь буурсан байх бөгөөд гэр бүлд үйлдэгддэг хүчирхийлэл, хүүхдийн эрхийн зөрчил 3-5 хувь буурна. Аймгийн хэмжээнд гэр бүлийн гишүүн бүр гэр бүлдээ хамтдаа хөгжих эерэг орчин бүрдүүлсэн 1000 загвар гэр бүл бий болно.



ЗАЛУУ МАНЛАЙЛАГЧ

“Залуу манлайлагч” хөтөлбөрийн хэрэгжүүлэгч: “Төгс голомт шийдэл” төрийн бус байгууллага



ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Өмнөговь аймгийн хэмжээнд 15-34 насны 23055 залуучууд байгаа бөгөөд эдгээр хүүхэд залуучуудын хэрэгцээ шаардлагыг системтэйгээр тодорхойлох судалгаа хийж, Өмнөговь аймгийн хүүхэд залуучуудын төлөөх бодлогод шийдвэрлэх үндэс суурь болгох, мөн сум бүрт манлайллыг дэмжих клуб байгуулан бусдыгаа манлайлах чадвартай хүүхэд залуучуудын чадварыг хөгжүүлэх шаардлагатай байгаа.

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ

2017 оны 2 дугаар сараас 12 дугаар сар хүртэл хоёр шатны судалгаа болон сургалтын ажил хийж, Өмнөговь аймгийн залуучуудын суурь судалгааны мэдээллийн бааз бүрдүүлснээр орон нутгийн залуучуудын хэрэгцээ шаардлагыг тодорхойлон аймгийн 15 сумын 15-34 насны залуучуудаас 3000-ыг манлайллын сургалтад хамруулна. Одоогийн байдлаар 15 сумын 647 хүүхэд залуучуудаас түүвэрлэлтийн аргаар


судалгаа авч, 26 мэргэжилтний ганцаарчилсан ярилцлага, 17 фокус бүлгийн ярилцлага авч байгаа.

ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ

Судалгааны үр дүнгийн гарын авлага 500 хувь хэвлүүлнэ. 50 салбар клубтэй болж, 15 шилдэг лектор тодруулан 100 албан байгууллагыг хамарч, 1000 залууст хүрч ажиллана. Уг хөтөлбөрийн хүрээнд 22 ерөнхий боловсролын сургууль, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн хоёр төвийг хамруулж, 100 чадваржсан сургагч багш бэлтгэж, сургалт, зөвлөх 150 үйл ажиллагаа явуулж, 2000 сурагчид хүрч ажиллана. Өмнөговь аймгийн хэмжээнд судалгаа хийж, 15-34 насны 3000 орчим залууг хамруулах бөгөөд 23055 залуугийн хэрэгцээ, хүсэл сонирхолд нийцсэн бодлогын шийдвэрүүд хэрэгжих боломжтой болно.

ОРОН НУТАГТ ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНД ЗӨВ СОЁЛТОЙ ОРОЛЦОХ МЭДЛЭГ ЧАДВАР

Орон нутагт замын хөдөлгөөнд зөв соёлтой оролцох мэдлэг чадвар эзэмшүүлэх хөтөлбөрийн хэрэгжүүлэгч: “Төгс голомт-шийдэл” төрийн бус байгууллага



ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Өмнөговь аймагт хотжилт болон хүн ам ихсэх тусам замын хөдөлгөөний дүрмийн тухай мэдлэг мэдээлэл иргэдэд ихээхэн шаардлагатай байна. Зам тээврийн ослын 17.5 хувь нь явган зорчигчийн буруугаас шалтгаалсны дотор гарц гарамгүй хэсгээр зам хөндлөн гарах, зорчих хэсгээр явах, гэрлэн дохионы заалт зөрчих, ойртон ирсэн тээврийн хэрэгслийн урдуур гэнэт гүйх зэргээр автомшинд мөргүүлэх, шүргүүлэх, дайруулах байдлаар гарсан гэсэн тоо баримт байна.

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ

Өмнөговь аймгийн Хүүхэд, гэр бүл хөгжлийн газар санаачлан хэрэгжүүлж буй энэхүү хөтөлбөрт Өмнөговь аймгийн Ханбогд, Баян-Овоо, Манлай сум тус бүрээс 50, Даланзадгад сумын дунд сургуулийн 100 сурагчийг хамруулж, нийт

250 хүүхдэд сургалт явуулах үе тэнгийн сургагч бэлтгэнэ. Одоогийн байдлаар хөтөлбөрийн зорилтот сумдаас тус бүр 50 хүүхдэд замын хөдөлгөөнд зөв соёлтой оролцох тухай сургалт хийсэн.

ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ

Зорилтот дөрвөн сумын 6-15 насны хүүхдүүдийн ойлголт хандлага 20 хувиар өөрчлөгдөнө. Үе тэнгийн найз нөхдөдөө орон нутгийн замын нөхцөл байдалтай уялдуулан ойлгомжтой, хялбар, сонирхолтой оролцооны хэлбэрээр сургалт зохион байгуулж, сургууль бүрт үе тэнгийн сургагч багш бэлтгэнэ. Замын хөдөлгөөнд зөв оролцох зурагт хуудас, гарын авлагатай болж, зам тээврийн ослоос хүүхдүүдийг урьдчилан сэргийлнэ.




ГОВИЙН БҮСИЙН СЭРГЭЭН ЗАСАХ ҮЙЛЧИЛГЭЭ

Говийн бүсийн сэргээн засах үйлчилгээ
хөтөлбөрийн хэрэгжүүлэгч: "Рехтус" ХХК



Гурвантэс



ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Өмнөговь аймгийн хэмжээнд сэргээн засах үйлчилгээний эмчилгээг зорилтот хүн амдаа үзүүлж чадахгүй байгаа бөгөөд бэлтгэгдсэн боловсон хүчин байхгүй нь энэ төрлийн эмчилгээг орон нутгийн хүн амд үзүүлэх боломжгүй байгаа учир уг чиглэлээр боловсон хүчинг бэлтгэх, улмаар үр дүнтэй ажиллах орчин нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ

Өмнөговь аймгийн ЗДТГ-ын захиалгаар "Рехтус" ХХК Өмнөговь аймгийн БОЭТ дээр сэргээн засах үйлчилгээний тасаг байгуулж, сэргээн засах эмчилгээг тогтмол үзүүлэх нөхцөлөөр хангах боломж бүрдүүлнэ. Бүрэн тохижилттой, орчин үеийн сэргээн засах тоног төхөөрөмжөөр иж бүрэн тоноглогдсон хөдөө

орон нутгийн хэмжээнд байгуулагдсан анхны сэргээн засах тасаг бий болох зорилгоор одоогийн байдлаар тоног төхөөрөмжүүдийг худалдан авч суурилуулан эмч, мэргэжилтэн бэлтгэж байгаа.

ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ

Энэхүү хөтөлбөр хэрэгжсэнээр Өмнөговь аймгийн анхны сэргээн засах үйлчилгээний тасаг бий болно. Сэргээн засах орчин үеийн чиг хандлага, онол, практикт суралцсан хоёроос доошгүй мэргэжлийн боловсон хүчин орон нутагт тогтвортой ажиллах боломж бүрдэнэ. Улмаар хоёр жилийн хугацаанд 8,000-аас доошгүй хүнд үйлчилсэн байх бөгөөд нийт үйлчлүүлэгсдийн 30-аас доошгүй хувьд нь эмчилгээний ахиц гарна.

ЧАДВАРЛАГ ЭМЧ

“Чадварлаг эмч” хөтөлбөрийн хэрэгжүүлэгч:
“Гумуда девелоп” ХХК



Гурвантэс

Даланзадгад

Мандал-Овоо

Сэврэй

Булган

Ханхонгор

Цогт-Овоо

Манлай

Цогтцэций

Баяндай

Баян-Овоо

Ханбогд

Ноён

Хүрмэн

Номгон

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Өмнөговь аймаг сүүлийн 10 жилд эх болон нярайн эндэгдлийн тоогоор улсдаа гуравт, бүс нутагтаа нэгт байгаа. БОЭТ-ийн үйлчлүүлэгчдээс авсан судалгаагаар нийт оролцогчдын 5 хувь нь сайн, 19 хувь нь сэтгэл ханамжгүй, 64 хувь нь дунд, 12 хувь нь муу гэж дүгнэсэн. Монгол улсын нийт аймгийн төрөлтийн түвшингээс Өмнөговь аймаг дахь төрөлтийн эндэгдэл 34 хувь илүү байдаг. Тиймээс Өмнөговь аймгийн эмч, эмнэлгийн албан хаагч нарын мэдлэг боловсрол, ажлын болон харилцааны ур чадварыг дээшлүүлэх, хууль эрх зүйн мэдлэг олгох, тоног төхөөрөмж дээрээ онц сайн ажилладаг болгох нэн тэргүүний шаардлага тулгараад байгаа юм.

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ

Өмнөговь аймгийн ЗДТГ-ын захиалгаар “Гумуда девелоп” ХХК Өмнөговь аймгийн БОЭТ-ийн үйлчилгээ, чанар, хүртээмжийг сайжруулах

зорилгоор эмнэлгийн өрөөнүүдийг камержуулж, нярайн тасгийг тохижуулан шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авч суурилуулан эмч мэргэжилтнүүдийн ур чадварыг дээшүүлэх сургалт хийх ажил явагдаж байна.

ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ


Энэхүү хөтөлбөр хэрэгжсэнээр БОЭТ-ийг 33 камераар тоноглон нэгдсэн системтэй болж, цусны шинжилгээний газрын хүлээлгийн танхим болон нярайн тасгийг тохижуулж, шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авч суурилуулан давхардсан тоогоор 250 эмч, сувилагчийн мэдлэг чадварыг дээшлүүлэх сургалтад хамруулж, тоног төхөөрөмжийг бүрэн ашигладаг болгон сургана. Ингэснээр нярайн эндэгдэл багасч БОЭТ-ийн үйлчилгээ сайжирч, өвчтөнийг чанарын өндөр түвшинд эмчилдэг болно.



2016 ОНД БАТЛАГДАН ХЭРЭГЖСЭН УЛАМЖЛАЛТ МАЛ АЖ АХУЙ, БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТИЙН ХӨТӨЛБӨРҮҮД

АРИУТГАЛ-2016

Ариутгал-2016 хөтөлбөрийн хэрэгжүүлэгч: Өмнөговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар



ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Өмнөговь аймаг 2015 оны жилийн эцсийн байдлаар 15 сум 51 багт 2,055,767 мал тоолуулж, мал бүхий иргэд 1580, үүнээс малчин 5417 өрхийн малын хашаа, хороо бууц 4798, үүнээс одоо ашиглаж буй 4617, худаг ус цэг 4632 тоолуулсан байна. Нийт мал сүргийн 70-80 хувь нь паразитаар өвчилж түүнээс шалтгаалан хорогдсоор байна.

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ

Өмнөговь аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, малчин иргэд "Говийн оюу хөгжлийн дэмжих сан"-тай хамтран энэхүү хөтөлбөрийг 2016 оны 6 дугаар сараас 11 дүгээр сарын хооронд хэрэгжүүлсэн бөгөөд Өмнөговь аймгийн 15 сумын 5417 малчин өрхийн 4617 өвөлжөө, хаваржааг ариутгасан.


ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ

Энэхүү хөтөлбөр хэрэгжсэнээр 5417 малчин өрхийн бууцыг ариутган Өмнөговь аймгийн нийт мал паразит өвчнөөс салж, өвчнөөс болж мал хорогдох явдал багассан. Хоол хүнсний чанар сайжран 4617 өвөлжөө, хаваржааг ариутган малын эрүүл мэнд сайжирсан сайшаалтай үр дүн гарсан.

2016 ОНД БАТЛАГДАН ХЭРЭГЖИЖ БАЙГАА УЛАМЖЛАЛТ МАЛ АЖ АХУЙ, БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТИЙН ХӨТӨЛБӨРҮҮД

ТАРИА

“Тариа” хөтөлбөрийн хэрэгжүүлэгч: “Манлайн эрин” хоршоо



ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Манлай суманд малын тэжээл бэлтгэх зорилгоор хоршооны гишүүд хамтарч гаргасан гүн өрмийн худаг болох “Цагаан моторт” нэртэй худгийг түшиглэн тариалангийн талбай байгуулж, малын тэжээлийн ургамал, төмс, хүнсний ногоо тарин хоршооныхоо өрхийг ногоогоор хангах, улмаар илүү гарсан ногоогоо зах зээлд борлуулах боломж байгаа учир хоршооны эзэмшлийн 0,25 га талбайг хашаалах хэрэгцээтэй байгаа.

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ

Хоршооны гишүүд хамтарч малын тэжээлийн ургамал, төмс, хүнсний ногоо тариалах 0,25 га талбайг хашин хамгаалж, “Манлайн эрин” хоршооны 54 гишүүнд эрдэнэ шиш тарих боллоцоотой болно. Одоогоор хашаа барих материал худалдан авах ажил хийж байгаа.

ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ

Уг хөтөлбөр хэрэгжсэнээр өвөл, хавар малаа тэжээх ургамал, үртэй болно. Ойр хөршийн малчдад эрдэнэ шишийн үр өгч туслан 54 гишүүн болон тэдгээрийн гэрийнхэн шууд ашиг хүртэнэ. Гишүүд хөнгөлөлттэй үнээр сум орон нутагтаа хямд үнэтэй ногоо нийлүүлэх боломжтой. Хоршооны гишүүд, ажилгүй иргэд ажиллах боломж бүрдэнэ.



2016 ОНД БАТЛАГДАН ХЭРЭГЖСЭН ҮНДЭСНИЙ ТҮҮХ СОЁЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨТӨЛБӨРҮҮД

МАНЛАЙН МУЗЕЙ

*“Манлайн музей” хөтөлбөрийн
хэрэгжүүлэгч: Манлай сумын соёлын төв*



ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Манлай сумын орон нутгийн судлах музей анх 1974 онд байгуулагдсан боловч тусгай байргүй учир хэд хэдэн байр сэлгэн нүүж одоогийн байрандаа 1994 орсон. Уг байгууламжинд хоёр танхим бий болгож, 1-р танхимд Манлай сумаас төрөн гарсан ахмад баатарлаг үйлстэн, алдар цуутнууд, төрийн түшээдийн намтар түүхийн зурагт самбар, сум орон нутагтай холбогдолтой бусад түүхэн олдворууд, 2-р танхимд сумын нутагт байдаг ан амьтны чихмэл, палеонтологийн олдвор бүхий чулуужсан яс гэх мэт байгалиас олдсон олдворууд байдаг. Орон нутгийнхаа түүх соёлыг сурталчлан таниулахын тулд стандартад нийцсэн музейтэй болох хэрэгтэй байгаа.

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ

Манлай сумын музейн тохижилтын ажлыг Манлай сумын соёлын төвөөс санаачлан 2016 оны 7 дугаар сараас 11 дүгээр сарын хооронд хийж гүйцэтгэн улсын коммист хүлээлгэн өгсөн. Уг хөтөлбөрийн хүрээнд хуучин барилгыг

шинэчлэн засварлаж шинээр дөрвөн танхимтай болгож үзмэрүүдийг тусгай гэрэлтүүлэг, хоргонд хийж бүрэн камержуулан дохиолол суулгаснаар сумын түүх, соёлын өв болсон дурсгалт зүйлсийн хадгалалт хамгаалалтыг сайжруулсан.


ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ

Манлай сумын орон нутгийн судлах музейн үзмэр, соёлын өвийг нутгийн болон гадаад, дотоодын иргэдэд үзүүлэн сурталчлах, орон нутгийнхаа түүх, соёлын өвийг танин мэдэхүйн боловсрол олгох чиглэлээр музейн стандартын дагуу тохижуулалт хийсэн. Орон нутгийн судлах музейг НСмузей өрөөг нэмэгдүүлж дөрвөн өрөөтэй болгосон. Үзмэрийн тоог нэмэгдүүлж, сан хөмрөгт хадгалагдаж буй үзмэрүүдийг ил байрлуулсан.

2016 ОНД БАТЛАГДАН ХЭРЭГЖИЖ БАЙГАА ҮНДЭСНИЙ ТҮҮХ СОЁЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨТӨЛБӨРҮҮД

ШАР ЦАВ, ХҮРДЭТ АГУЙН СОЁЛЫН ӨВИЙГ АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛТАЙ ХОСЛУУЛАН ХАМГААЛАХ

Шар цав, Хүрдэт агуйн соёлын өвийг аялал жуулчлалтай хослуулан хамгаалах хөтөлбөрийн хэрэгжүүлэгч: Палеонтологийн олдворыг хамгаалах нийгэмлэг



ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Өмнөговь аймгийн Манлай сумын Өгөөмөр багийн нутаг, Манлай сумаас урагш 108 км-т орших Шар цавын 4-5 төрлийн үлэг гүрвэлийн 6-70 см урттай 18,000 гаруй мөр, Ханбогд сумын Жавхлант багаас баруун тийш 18 км-т орших Хүрдэт агуйн 18-20-р зууны эхэн үеийн 32 бүлэг хятад, монгол, төвд бичээс бүртгэгдэн үлдсэнийг хамгаалалтад аваагүйгээс соёлын өвийн үл хөдлөх дурсгалт газрууд байгаль цаг уур болон хүний буруутай үйл ажиллагаанаас хамаарч устан үгүй болохоос сэргийлэх ажил зохион байгуулж, гадаад, дотоодын жуулчдыг татах цогц байгууламж бий болгох шаардлагатай байна.

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ

Энэхүү хөтөлбөрийг Өмнөговь аймгийн ЗДТГ захиалан Палеонтологийн олдворыг хамгаалах нийгэмлэг хэрэгжүүлж байгаа бөгөөд Манлай болон Ханбогд сумын нэр заасан байршилд ажиллан Өмнөговь аймгийн бахархал болсон соёлын өвийг хадгалан хамгаалж, стандартад нийцсэн барилга байгууламжтай болгож, жуулчдыг хүлээн авч үл

хөдлөх дурсгалт газрыг таниулан сурталчлах геопарк бий болгох ажил 95 хувьтай явагдаж байна.

ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ

Шар цав, Хүрдэт агуйн өвт газруудын дурсгалыг сэргээх, бэхжүүлэх, хамгаалах, дэд бүтцийн бүтээн байгуулалтыг стандартын дагуу хийж гүйцэтгэнэ. Уг Шар Цав, Хүрдэт агуйн соёлын өвийн үл хөдлөх дурсгалт газруудыг хамгаалснаар хойч үедээ өвлүүлэн үлдээх, тус бүс нутгуудад түшиглэсэн аялал жуулчлалын дэд бүтцийг байгуулж, орон нутгийн эдийн засгийн тогтвортой хөгжилд хувь нэмрээ оруулна. Өмнөговь аймагтаа анхдагч үлэг гүрвэлийн мөрт газрын хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, судалгаа шинжилгээний байнгын ажиллагаатай бааз суурийг бий болгох, "геопарк"-ийн тогтолцооны үндэс суурь тавигдана. Ингэснээр Өмнөговь аймгийн зүүн хэсгийн аялал жуулчлалын кластер төлөвлөгөө, орон нутгийн иргэдийн санал санаачилгын хүрээнд цогц аялал зохион байгуулах бүрэн боломж нээгдэнэ.



АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЛБАРЫН ХӨГЖИЛ-ЖУУЛЧДЫГ ТАТАХ СУРГАЛТ, СУРТАЛЧИЛГАА

Аялал жуулчлалын салбарын хөгжил-жуулчдыг татах сургалт сурталчилгаа хөтөлбөрийн хэрэгжүүлэгч: “Улаанбаатар телевиз” ХХК



Гурвантэс

Сэврэй

Булган

Ханхонгор

Цогт-Овоо

Манлай

Даланзадгад

Цогтцэций

Баяндалай

Баян-Овоо

Ханбогд

Ноён

Хурман

Номгон

ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Аялал жуулчлалыг хөгжүүлэхэд аймгийн хэмжээнд анхаарч Аялал жуулчлалын мастер төлөвлөгөө боловсруулах зэргээр ажиллаж байгаа ч аялал жуулчлалын салбарын орлого мэдэгдэхүйц хэмжээнд өсөх, жуулчдын тоо хангалттай хэмжээнд нэмэгдэх өөрчлөлт гарахгүй байна. Өмнөговь аймгийн аялал жуулчлалын байгалийн үзэсгэлэнтэй, сонирхолтой гол зорин очих газрууд, тус аймгийн нэг онцлог болсон уул уурхай, түүнийг түшиглэн хөгжиж болох уул уурхайн аялал жуулчлал, нүүдэлчин малчдын ахуй амьдрал, ёс заншил, говийн брэнд бүтээгдэхүүнүүд, мөн хил орчмын аялал жуулчлал зэргийг сонирхолтойгоор таниулах баримтат кино бүтээлгэх хэрэгцээтэй байна.

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ

Энэхүү хөтөлбөрийг Өмнөговь аймгийн ЗДТГ захиалан “Улаанбаатар телевиз” ХХК хэрэгжүүлж байгаа бөгөөд одоогийн байдлаар зураг авалт


хийх газруудтай танилцан фонд бүрдүүлж, баримтат киноны анхан шатны зураг авалт хийсэн.

ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ

Өмнөговь аймгийн онцлогийг тодруулан харуулах уул уурхай, эко аялал жуулчлал, малчин өрх, уламжлалт ёс заншил, говийн брэнд бүтээгдэхүүн, хил орчмын аялал жуулчлал гэсэн таван сэдвээр 8-10 цуврал баримтат кино бүтээлгэж, гадаад дотоодын зорилтот орны хэвлэл мэдээллээр цацаж сурталчлан таниулна. Өмнөговь аймгийг чиглэсэн аялал жуулчлал ихэсч, түүнийг дагаж орон нутгийн бизнесүүд ашиг орлоготой болно.

ҮНДЭСНИЙ ӨВ СОЁЛ, МЭДЛЭГ УХААНЫГ ХҮҮХЭД ЗАЛУУСТ ӨВЛҮҮЛЭН ҮЛДЭЭХ СУРГАЛТ

Үндэсний өв соёл, мэдлэг ухааныг хүүхэд залууст өвлүүлэн үлдээх сургалт хөтөлбөрийн хэрэгжүүлэгч: Ханбогд сумын ахмадын хороо



ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Орчин үеийн дэвшилтэт технологи хүний амьдралд нэвтэрч, өдөр тутмын хэрэглээ болж, хөдөлмөр хөнгөвчилж байгаа ч энэ хэрээр шинэ үеийн залуус уламжлалт амьдралын хэв маягаас алхам алхмаар холдож, гадаад орны соёлын хүчтэй нөлөөнд автаж байгаа энэ үед уламжлалт ёс заншлаа хадгалан үлдэж, өвлүүлэх нь үндэсний үнэт зүйлээ хойч үедээ үлдээх нь нэн тэргүүний авч хэлэлцэх асуудал болсон байна.

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ

Хүүхэд залууст монгол гэрийн тухай, хэрхэн барих, мал маллагаа болон малын гаралтай бүтээгдэхүүнүүдийг хэрхэн бэлтгэх, эмийн болон тэжээлийн ургамал бэлтгэх, боловсруулах, үндэсний хувцас, эд хэрэглэлтэй холбогдолтой бүхий л мэдлэг, мэдээллийг сургаж, өвлүүлж байна.

ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ


Ханбогд сумын хүүхэд залуучуудын уламжлалт амьдрах ухаан, өв соёлын талаарх мэдлэгийг дээшлүүлэх, ахмад дээд үеийнхнийхээ хийж, хэрэглэж ирсэн уламжлалаас өвлөн суралцаж, өв соёлоороо бахархах сэтгэлгээг төлөвшүүлнэ. Хүүхэд залуучуудаар дамжуулан орон нутгийн онцлогтой аман түүх, домог хууч сурвалжлан цуглуулж, хадгалан хамгаалах ажил хийсэн байна. Малч ухаан, соёлын уламжлалт мэдлэг, арга ухааныг залуучуудад өвлүүлэн үлдээж, үндэснийхээ соёлыг хадгалан хамгаалах, үндэсний ухамсарт хувь нэмэр оруулна.



2016 ОНД БАТЛАГДАН ХЭРЭГЖИЖ БАЙГАА УСНЫ МЕНЕЖМЕНТИЙН ХӨТӨЛБӨР

НУТГИЙН ИРГЭДЭД ТУЛГУУРЛАСАН УСНЫ ЧАНАРЫН ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭ

Нутгийн иргэдэд тулгуурласан усны чанарын хяналт, үнэлгээ хөтөлбөрийн хэрэгжүүлэгч: Өмнөговь аймгийн Скаутын холбоо



ТӨСЛИЙН ҮНДЭСЛЭЛ, ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГА

Өмнөговь аймгийн хүүхэд залуучуудад чиглэсэн усны ач холбогдлын тухай мэдлэг мэдээлэл олгох сургалт төдийлөн зохион байгуулагддаггүй. Дэлхийн томоохон улсуудын туршлагаас харахад АНУ-ын усан орчны судалгаа гэх мэт хүүхэд залуучуудад чиглэсэн ажлыг жил бүр хийдэг байна. Байгаль дэлхий, тэр дундаа усыг хайрлан хамгаалах ухааныг заахын тулд газар дээр нь судалгаа шинжилгээтэй цогц сургалт хийх ёстой гэдэг туршлага дээр үндэслэн энгийн хялбаршуулсан байдлаар олон улсын цахим хөтөлбөрийг нэвтрүүлэхийг зорьсон юм.

ТӨСЛИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖИЛ

Хөтөлбөрийн хүрээнд Ханбогд, Баян-Овоо, Манлай, Даланзадгад сумын долоон сургуулийн эко клубын 240 орчим сурагчид усны чанарт хяналт үнэлгээ хийх шинжлэх ухааны үндэслэлтэй мэдлэг олгох, судалгаа хийх аргыг зааж сургах, хичээлээр олж авсан мэдлэг, туршлага дээрээ

үндэслэн өөрийн орон нутгийн булаг шандны усны бохирдлын мониторинг үнэлгээ хийх, орон нутагт байгаа булаг шандны усаа хайрлах, хамгаалах талаар сургалт хийнэ. Одоогоор хөтөлбөрийн бэлтгэл ажил хангагдаад байна.

ТӨСЛИЙН ҮР ӨГӨӨЖ

Энэхүү хөтөлбөр хэрэгжсэнээр Түншлэгч дөрвөн сумын 240 орчим сурагч өөрсдийн хийсэн хяналт үнэлгээн дээрээ тулгуурлан усны чанарын талаарх ерөнхий ойлголттой болж, эко клубээр дамжуулан бусад үе тэнгийнхэндээ мэдээлэл түгээнэ. Дөрвөн сумын долоон сургуулийн эко клубын сурагчдын булаг шандны усаа хамгаалж буй арга нь бусад сургуулиудын сурагчдад туршлага болох бөгөөд гарын авлага, арга зүйгээ хуваалцана. Ингэснээр хүүхэд багачууд усыг зөв ашиглан ариг гамтай болж өсч хүмүүжинэ.

ХАРИЛЦАГЧ БАЙГУУЛЛАГУУД



“Оюу толгой” ХХК нь Хамтын ажиллагааны гэрээний хүрээнд “Говийн оюу ХДС”-г үүсгэн байгуулсан. “Оюу толгой” ХХК календарийн жил бүр таван сая ам.долларыг сайн дурын санхүүжилт хэлбэрээр “Говийн оюу хөгжлийг дэмжих сан”-д төвлөрүүлж Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад хувь нэмэр оруулж байгаа.



Өмнөговь аймаг нь Хамтынажиллагааны гэрээний нэг тал. Өмнөговь аймгийн Ханбогд сум нь Хамтын ажиллагааны гэрээний нэг тал. Түншлэгч сумдын нэг юм. Өмнөговь аймгийн Баян-Овоо сум нь Хамтын ажиллагааны гэрээнд заасанчлан Түншлэгч сумдын нэг юм. Өмнөговь аймгийн Даланзадгад сум нь Хамтын ажиллагааны гэрээнд заасанчлан Түншлэгч сумдын нэг юм. Өмнөговь аймгийн Манлай сум нь Хамтын ажиллагааны гэрээнд заасанчлан Түншлэгч сумдын нэг юм.



“Хүннүгийн говь” ХХК нь Даланзадгад сумын 25-р цэцэрлэгийн барилга угсралтын ажлыг амжилттай хэрэгжүүлж улсын коммист хүлээлгэн өгсөн.



“Жи Жи Ай” ХХК нь Даланзадгад сумын 26-р цэцэрлэгийн барилга угсралтын ажлыг амжилттай хэрэгжүүлж улсын коммист хүлээлгэн өгсөн.



“Суварган говь” ХХК нь Баян-Овоо сумын эмнэлгийн барилга угсралтын ажлыг амжилттай хэрэгжүүлж улсын коммист хүлээлгэн өгсөн.



“Говийн өгөөж” ХХК нь Даланзадгад сумын 2-р сургуулийн заалны барилга угсралтын ажлыг амжилттай хэрэгжүүлж улсын коммист ?????хүлхүллхүлээлгэн өгсөн.



“Говийн газар шороо” ТББ нь Ханбогд суманд мод үржүүлгийн газар байгуулж цөлжилттэй тэмцэх ажил хийж байгаа.



Өмнөговь аймгийн Хүнс Хөдөө Аж Ахуйн Газар нь Оюу Хүлэмж хөтөлбөрийг Өмнөговь аймгийн нийт сумдад хэрэгжүүлж байгаа.



“Бат цайз” хоршоо нь Манлай суманд мод тарьж Манлай сумын элсний нүүдлийг багасгаж цөлжилттэй тэмцэх ажил хийж байгаа.



ХАРИЛЦАГЧ БАЙГУУЛЛАГУУД



Өмнөговь аймгийн Насан туршийн боловсрол төв нь Даланзадгад суманд Хотын соёл хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн.



“Оюуны өргөө” ТББ нь Өмнөговь аймгийн нийт сумдад хувь хүний хөгжлийн сэдэвт “Сургалт” хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн.



Ханбогд сумын сум дундын эмнэлэг нь “Эрүүл малчин” хөтөлбөр хэрэгжүүлж, Ханбогд сумын төвөөс алслагдсан иргэдэд явуулын эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлж байгаа.



Монголын Палеонтологийн олдворийг хамгаалах нийгэмлэг ТББ нь “Шар цав, Хүрдэт агуйн соёлын өвийг аялал жуулчлалтай хослуулан хамгаалах” хөтөлбөрийг хэрэгжүүлж байгаа.

САНХҮҮГИЙН ТАЙЛАН

БАЛАНС

Үзүүлэлт	31/12/2015	31/12/2016
Үндсэн хөрөнгө		
-Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	974,166.10	6,768,726.2
-Үндсэн хөрөнгө	695.0	14,360.0
-Үндсэн хөрөнгийн элэгдэл		-2,480.8
НИЙТ ХӨРӨНГӨ	974,861.1	6,780,605.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө		
-Цэвэр хөрөнгө	974,861.1	6,780,605.4
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЦЭВЭР ХӨРӨНГӨ	974,861.1	6,780,605.4

ОРЛОГЫН ТАЙЛАН

Үзүүлэлт	31/12/2015	31/12/2016
Үйл ажиллагааны орлого		
-Хөрөнгө оруулалтын орлого	3,993,980.00	10,024,900.00
Үйл ажиллагааны орлогын нийт дүн	3,993,980.00	10,024,900.00
Үндсэн үйл ажиллагааны зардал		
-Төсөл хэрэгжүүлсний зардал	3,010,722.40	4,051,415.40
-Ерөнхий удирдлагын зардал	8,396.50	167,740.20
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	3,019,118.90	4,219,155.60
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ/АЛДАГДАЛ	974,861.10	5,805,744.30
ТАЙЛАНТ ҮЕИЙН ЦЭВЭР ДҮН	974,861.10	5,805,744.30

МӨНГӨН УРСГАЛЫН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	31/12/2015	31/12/2016
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
-Хүлээн авсан санхүүжилт	3,993,980.0	10,024,900.0
Үйл ажиллагааны мөнгөн орлого	3,993,980.0	10,024,900.0
-Ажиллагчдад олгосон мөнгө	2,795.8	63,171.4
-Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	307.5	6,948.9
-Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө	5,057.3	67,931.0
-Ашиглалтын зардалд төлсөн мөнгө		27,116.7
-Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	235.9	91.6
-Төсөл, хөтөлбөрт зарцуулсан мөнгө	3,010,722.4	4,051,415.4
Үйл ажиллагааны мөнгөн зарлага	3,019,118.9	4,216,674.9
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	975,106.1	5,808,225.1



ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
-Худалдаж авсан урт хугацаат хөрөнгө	695.0	13,665.0
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	695.0	13,665.0
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	974,166.1	5,794,560.1
МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	0.0	974,166.1
МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	974,166.1	6,768,726.2

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	Хуримтлагдсан үр дүн	Нийт Дүн
2015.01.01-ний үлдэгдэл	0	0
Тайлант үеийн цэвэр үр дүн	974,861.1	974,861.1
2015.12.31-ний үлдэгдэл	974,861.1	974,861.1
2016.01.01-ний үлдэгдэл	974,861.1	974,861.1
Тайлант үеийн цэвэр үр дүн	5,805,744.3	5,805,744.3
2016.12.31-ний үлдэгдэл	6,780,605.4	6,780,605.4